

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.			
Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Үнэт цаас гаргагчийн нэр: Монложистикс холдинг ХК Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 6381251 Үнэт цаасны код: MN00MLG05696 Утасны дугаар: 7701-5454		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Тээврийн салбар		
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Грант Торнтон Аудит ХХК Аудитаар бүртгүүлсэн огноо: 2017 оны 11 сарын 24		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	395,858,822 ширхэг		
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ц. Дуламсүрэн /ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга/ Хянасан: Г.Хишигбат /Гүйцэтгэх захирал/		
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН			
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Мянган төгрөгөөр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Эргэлтийн хөрөнгийн дүн	54,577,331	82,080,343
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,031,411	10,274,967

		Нийт хөрөнгийн дүн	57,608,742	92,355,310
		Өр төлбөрийн нийт дүн	14,169,257	43,704,813
		Эздийн өмчийн дүн	43,439,485	48,650,498
		Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	57,608,742	92,355,310
	Орлогын тайлан	Мянган төгрөгөөр	2023 он	2024 он
		Борлуулалтын орлого	210,360,690	296,858,006
		Нийт ашиг	18,108,007	24,381,457
		Татвар төлөхийн өмнөх ашиг	9,585,276	11,946,260
		Орлогын татварын зардал	(1,222,411)	(1,599,812)
		Татварын дараах ашиг	8,362,865	10,346,448
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Мянган төгрөгөөр	2023 он	2024 он
		Өмч	118,758	118,758
		Халаасны хувьцаа	-	-142,740
		Нэмж төлөгдсөн капитал	10,187,611	10,187,611
		Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-211,818	-306,648
		Хуримтлагдсан ашиг	29,190,901	33,752,909
		Нийт дүн	39,285,452	42,325,230
		Хиналтын эрхгүй хувь оролцоо	4,154,032	6,325,268
		Нийт дүн	43,439,484	48,650,498
	Мөнгөн гүйлгээний тайлан	Мянган төгрөгөөр	2023 он	2024 он
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,480,166	(13,598,306)
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,390,252)	(14,461,999)
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,037,090	15,142,180
		Валютын ханшийн зөрүү	(203,426)	(494,872)
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	7,923,578	(13,412,997)
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,198,308	22,121,885
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,121,885	8,708,888
1.1.	Жилийн санхүүгийн тайлангын аудитын дүгнэлт:			
	- Монложистике Холдинг ХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлангийн 6-10-р хуудаснаас харна уу. Хавсралтаар оруулав.			

1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/			
	- байхгүй			
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл			
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Харьцаанууд	2023 он	2024 он
		Нийт ашгийн хувь	8.6%	8.2%
		Цэвэр ашгийн хувь	4.0%	3.5%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	19%	22%
		Нэгж хувьцаанд ноогдох ашиг	14.97	18.54
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Харьцаанууд	2023 он	2024 он
		Эргэлтийн харьцаа	3.98	2.20
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	3.43	1.36
		Өрийн харьцаа	0.25	0.47
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Гадаад орчны зүгээс Орос, Украины дайны нөхцөл байдал нь ачаа тээврийн маршрут, хил гаалийн хяналт болон төлбөр тооцоонд тодорхой нөлөөл үзүүлж байна. Энэхүү нөхцөл байдал үйлчилүүлэгч нарт тогтмол мэдээллээр хангаж, боломжит тээврийн маршрутыг санал болгон ажиллаж байна. Олон улсын ОХУ эсрэг авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээнүүдийн дагуу хоригт аливаа хэлбэрээр орсон байгууллага хувь хүнтэй харьцахгүй байх дээр анхааран ажиллаж байна.		
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй болно.		
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Монложистике групп нь - ИВЕС банк: Вагоны хөрөнгө оруулалтанд 14,654,000 CNY, - ХХБ банк: Шугамын зээл 6 тэрбум төгрөг, 2024-12-31 нээр ашиглаагүй байна. - Голомт банк: Шугам 2,5 тэрбум төгрөг - Хаан банк: Шугам 3,5 тэрбум төгрөг		
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/			

Монложистик Холдинг ХК-ийн ТУЗ-өөс “Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ыг 2024 онд шинээр баталсан. Монгол Улсын Компанийн тухай хууль болон холбогдох дүрэм журамд заасан дагуу дараах хэлцлүүдийг ТУЗ-өөр хэлэлцэж, баталсан.

1. ТУЗ-ийн 2024 оны 2-р сарын 07-ны өдрийн №24/ТУЗ/09 тоот тогтоолоор дараах 5 сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хийхийг зөвшөөрсөн: Үүнд:

№	Монложистикс Холдинг ХК-тай Менежментийн үйлчилгээний гэрээ байгуулах охин компанийн нэр	Гэрээний үнийн дүн
1	Монложистикс Ворлдвайд ХХК	172,800,000 төгрөг
2	Монложистикс Транзит ХХК	43,000,000 төгрөг
3	Монложистикс Карго ХХК	3,000,000 төгрөг
4	Монложистикс Тракинг ХХК	3,000,000 төгрөг
5	Каус Аустралис ХХК	4,000,000 төгрөг

2. ТУЗ-ийн 2024 оны 3-р сарын 26-ны өдрийн №24/ТУЗ/14 тоот тогтоолоор дараах их хэмжээний хэлцлийг хийх зөвшөөрлийг Монложистикс Экүйпментс ХХК-д олгосон. Үүнд:

№	Гэрээний төрөл	Гэрээний тал	Гэрээний зүйл	Үнийн дүн
1	Вагон нийлүүлэх гэрээ	PM Рейл Азия, Казахстан	10 ш вагон	Нэг бүрийн 60,000 ам доллар, нийт 600,000 ам доллар
2	Зээлийн гэрээ	ИБЕС	Вагон худалдан авах санхүүжилт буюу зээл	200,000,000 рубль хүртэл (түүнтэй тэнцэх валют)

3. ТУЗ-ийн 2024 оны 7-р сарын 22-ны өдрийн №24/ТУЗ/29 тоот тогтоолоор дараах их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсөн. Үүнд:
Компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор Худалдаа хөгжлийн банкнаас зээл авах, тус банктай “Зээлийн эрх нээх гэрээ” байгуулахыг “Монложистикс Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д зөвшөөрсөн.

4. ТУЗ-ийн 2024 оны 7-р сарын 29-ны өдрийн №24/ТУЗ/33 тоот тогтоолоор дараах их хэмжээний хэлцлийг хийх зөвшөөрлийг Монложистикс Экүйпментс ХХК-д олгосон. Үүнд:

№	Гэрээний төрөл	Гэрээний тал буюу нийлүүлэгч	Гэрээний зүйл	Үнийн дүн
1	Вагон нийлүүлэх гэрээ	RM Rail Trading company LLC, ОХУ	40 ш Полувагон, модель 12-1293	Нэг бүрийн 58,500 ам доллар, нийт 2,340,000 ам доллар (үүнээс 30% өөрийн хөрөнгөөр)
2	Зээлийн гэрээ	ИБЕС эсвэл Хаан банк	Вагон худалдан авах санхүүжилт буюу зээл	7 тэрбум төгрөг (70% зээл)

Их хэмжээний хэлцэл: 3
Сонирхлын зөрчилтэй хэлцэл: 5


4.	Цалин урамшууллын мэдээлэл
	<p>ТУЗ-ийн цалин урамшуулал: ТУЗ-ийн дарга болон гишүүдийн цалингийн хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос тодорхойлон санал боловсруулж, 2024 оны 4-р сарын 27-ны өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Батлагдсан төсвийн хүрээнд 2024 онд ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалин 936,024,543 сая төгрөг, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдэд олгосон цалин болон урамшуулал нийт 287,992,808 сая төгрөг байна.</p>
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
	<p style="text-align: center;">ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ</p> <p>Монложистикс Холдинг ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд удирдлага юм. Монложистикс Холдинг ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурлыг 2024 оны 4-р сарын 27-ны өдөр зайнаас буюу цахим хэлбэрээр зохион байгуулж, шууд дамжуулалтыг хурлын платформоор болон фэйсбүүк дэхь Monlogistics Group пэйж хуудсаар олон нийтэд шууд дамжуулан хүргэсэн.</p> <p>Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц 85.57%-иар бүрдэж, хүчин төгөлдөр явагдсан. Хуралд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Гүйцэтгэх захирал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г. Хишигбат компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлахын өмнө компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг товч танилцуулж; 2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э. Оюунбилэг компанийн ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж; 3. Хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н. Эрдэнэцог компанийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг тус тус танилцуулж, хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултанд хариулж оролцсон. <p>Хурлаас гарсан шийдвэр:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монложистикс Холдинг ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батласан. 2. Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны төсвийг батласан.
	<p style="text-align: center;">ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ</p> <p>Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хурдацтай өөрчлөгдөж буй бизнесийн талбарт үүсч болох эрсдэл ба боломжийг амжилттай удирдах салбар салбартаа мэргэшсэн, туршлагатай гишүүдээс бүрддэг бөгөөд ердийн 5, хараат бус 4, нийт 9 гишүүнтэй.</p> <p>ТУЗ-ийн үйл ажиллагаа</p>

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал бөгөөд Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ нь 2024 онд ээлжит болон ээлжит бус нийт 7 удаагийн хурал зохион байгуулж, гишүүд идэвх санаачлагатай оролцсон бөгөөд хурлын дундаж ирц 96,7% байсан. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ТУЗ-ийн хурлаас болон ТУЗ-ийн гишүүдээс эчнээ санал хураалт явуулах замаар 2024 онд ТУЗ-өөс нийт 60 тогтоол баталж, гүйцэтгэх удирдлагад зөвлөмж, чиглэл, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажилласан.

ТУЗ-ийн дэргэдэх Хороодын үйл ажиллагаа

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2024 онд биечлэн болон цахим хэлбэрээр хуралдаж, хороодын ажлын чиг үүргийн дагуу идэвх санаачлагатай ажилласан.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурал



ТУЗ-ийн сургалт хөгжил

ТУЗ-ийн гишүүдийн сургалтын хөтөлбөрийн дагуу “Дижитал шилжилт” болон “Тээвэр ложистикийн салбарын өнөөгийн байдал” сэдвээр 2 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

ТУЗ-ийн үнэлгээ

ТУЗ, түүний гишүүд болон Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, Дотоод аудиторын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх замаар ТУЗ-ийн гишүүдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх, манлайлах, ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулан компанийн сайн засаглалыг бэхжүүлэх зорилгоор ТУЗ-ийн гүйцэтгэлийг үнэлэх журмыг 2024 онд шинээр баталсан.

ТУЗ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ нь дараах үнэлгээнүүдээс бүрдэх бөгөөд үнэлгээний асуулгуудыг компанийн засаглалын олон улсын сайн туршлага, кодексийн зарчим дээр үндэслэн боловсруулсан.

НДБЦУХороо нь ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2024 оны ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэлтийг ТУЗ-ийн 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хуралд танилцуулж, хэлэлцүүлсэн.

Компанийн засаглалын зарчмуудын хэрэгжилт, өөрийн үнэлгээ, хянан баталгаажилт

Компанийн засаглалын зарчмуудыг зөв зохистой хэрэгжүүлэх нь засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, итгэлцлийг бий болгох, компанийг эрсдэлээс хамгаалж, тогтвортой үнэ цэнийг бүтээх чухал ач холбогдогдолтой.

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж болон үнэлгээний аргачлал”-ын дагуу Монложистике Холдинг ХК-ийн ТУЗ-өөс Монложистике Холдинг ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг 2024 онд анх удаа үнэлсэн.

Монложистике Холдинг ХК нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа нийт компаниуднаас “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн 97,2%-ийн үнэлгээтэйгээр, эзлүүлсэн байр буюу засаглалын зэрэглэлээр 2024 онд 2-р байрт, Компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч ТОП 20 компанийн нэгээр шалгарсан.

Ил тод байдал, тайлагнал

Монложистике Групп нь үйл ажиллагаандаа бизнесийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, олон нийтэд компанийн үйл ажиллагааны талаарх болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг нээлттэй, ил тод байлгаж, үнэн зөв, бүрэн гүйцэт, түргэн шуурхай тогтмол мэдээлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.

Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам” болон Монложистике Холдинг ХК-ийн “Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ын хэрэгжилтийг хангаж, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад болон бусад оролцогч талуудад мэдээллийг нэг сувгаар хүргэх зорилгоор <https://investor.mlholding.mn/> цахим хуудсыг 2024 онд шинээр ашиглалтанд оруулсан.

2024 онд <https://investor.mlholding.mn/> цахим хуудсанд болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд дараах мэдээллүүдийг байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээллэсэн байна.

ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монложистике Групп нь “Гурван шугамын загвар”-ийн зарчмаар дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн, үйл ажиллагааны бүхий л шатанд хяналтыг чиг үүргийнхээ дагуу дараах байдлаар хэрэгжүүлэн ажилладаг.

Монложистике Групп нь дараах үйл ажиллагаануудад тасралтгүй хяналт тавьж, бизнесийн үйл ажиллагааг эрсдэлгүй, тогтвортой явуулахад анхааран ажилладаг. Үүнд:

1. Компанийн засаглал, мөрдөгдөж буй дүрэм журам, эрх зүйн баримт бичгүүдийн нийцлийг үнэлэх, зөвлөмж өгөх;
2. Бизнес төлөвлөгөө, түүний хэрэгжилт, гадаад, дотоод орчны нөлөөллийн эрсдэлийг тодорхойлох, түүнд хариу арга хэмжээ авах үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, зөвлөмж өгөх;
3. Дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
4. Удирдлагын тогтолцооны стандартуудын хэрэгжилтэд дотоод аудит хийх, зөвлөмж өгөх, аудитын дагуу хийсэн сайжруулалтын үр нөлөөтэй байдлыг үнэлэх;

Монложистике Группийн хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Employee day” арга хэмжээний хүрээнд 2024 оны 5-р сард дотоод аудитыг сурталчлах сарын аяныг эхлүүлж, группийн хэмжээнд зургаан төрлийн ажлыг амжилттай зохион байгууллаа. ТУЗ-ийн Дотоод аудитор Б.Тамжиддорж 2024 оны 4-р сард Монголын Дотоод Аудиторуудын

Институтийн албан ёсны эрхтэй “Үндсэн шалтгааны шинжилгээ хийж дотоод аудитын үр нөлөөг дээшлүүлэх нь” сургалтыг орчуулан бэлтгэж, хамтран зохион байгууллаа.

Группийн хэмжээнд хийгдсэн Дотоод хяналтын тогтолцооны үнэлгээ

Компанийн нийт ажилтнуудаас СОСО загвараар судалгаа авч, үр дүнг нэгтгэн ТУЗ-ийн дэргэдэх АЭУХороонд танилцуулж, зөвлөмж авсан. Судалгааны үр дүнг 2023 онтой харьцуулахад засаглалын үнэлгээ, дотоод хяналтын тогтолцооны үнэлгээ, эрсдэлийн удирдлагын үнэлгээ тус тус өссөн үзүүлэлттэй гарсан нь бид дотоод хяналтын тогтолцоогоороо дамжуулан засаглал, эрсдэл, хяналтын функцүүдийг богино хугацаанд үр нөлөөтэй зохион байгуулж хэрэгжүүлэн ажиллаж чадаж байгаагийн нэг илэрхийлэл болж байна.

6. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

Группийн хэмжээнд нийт 6 охин компанид Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэнтэй холбогдуулан “Эрсдэлийн удирдлагын журам”-ыг 2025 оны 11-р сард шинэчлэн баталлаа. Мондожистикс Группийн хэмжээнд бизнесийн, тактикийн болон үйл ажиллагааны (ХАБЭА) түвшний эрсдэлүүдийг үнэлэн тогтоож, эрсдэлийн нөлөөллийг бууруулах, боломжийг ашиглах төлөвлөгөөг охин компани бүрийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан боловсруулж, хэрэгжүүлдэг.

Энэхүү шинэчилсэн “Эрсдэлийн удирдлагын журам”-аар Группийн Эрсдэлийн баг, компани бүрийн эрсдэл хариуцсан ажилтнууд, тэдгээрийн үйл ажиллагааны процесс зураглал, хэрэгжүүлэх алхмуудыг илүү оновчтой зохион байгуулсны зэрэгцээ эрсдэл, боломжийн түвшинг тогтоох шатлал, аргачлалыг тодорхойлж, хяналт тайлагналын арга замуудыг нарийвчлан журамласан.

Өнгөрөгч 2024 онд Мондожистикс Группийн хэмжээнд гадаад болон дотоод орчны нийт 68 эрсдэлийг PESTLE, Porter’s 5, McKinsey 7S зэрэг олон улсын стандарт аргачлалын дагуу тодорхойлсны дотор хөрш орнуудын дайны нөхцөл байдлаас үүдсэн санхүүгийн хориг, тээврийн маршрутын өөрчлөлт, ханшийн эрсдэл, улс хоорондын төлбөр тооцооны эрсдэлүүд хамгийн өндөр түвшинд байлаа. Эдгээр гадаад хүчин зүйлсээс шалтгаалсан эрсдэлүүдээс гадна дотоод орчинд эдийн засгийн хямрал, түүхий эдийн ханшийн уналт 2025 онд ч мөн үргэлжилж, ачаа эргэлтийн хугацаа удаашрах, тээврийн өртөг нэмэгдэх, хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурах, инфляц, гадаад валютын ханш өсөх зэрэг Группийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөхүйц нөхцөл байдлыг үүсгэх магадлал өндөр байна.

7. Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид:

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо ширхэг	Эзлэх хувь
Л. Ганзоригт	113,215,623	28.6%
Б. Тэлэнгэд	113,215,623	28.6%
Г. Хишигбат	31,668,705	8.0 %
А. Одгэрэл	31,668,705	8.0 %

	Хувьцаа эзэмшигчдийн тоо (2024-12-31 байдлаар): 1481 хувьцаа эзэмшигч																												
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл																												
	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө																												
	Зарцуулалтын тайлан: Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт																												
	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын Дүн (сан.төгрөг)</th> <th>Төлөвлөгөө</th> <th>Зарцуулалт</th> <th>Үлдэгдэл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт</td> <td>8,062</td> <td>1502</td> <td>3060</td> </tr> <tr> <td>2</td> <td>Эргэлтийн хөрөнгө</td> <td>2,923</td> <td>2,923</td> <td></td> </tr> <tr> <td>3</td> <td>Төв азийн зам</td> <td></td> <td>3,500</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Нийт</td> <td>10,985</td> <td>7,925</td> <td>3,060</td> </tr> </tbody> </table>				№	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын Дүн (сан.төгрөг)	Төлөвлөгөө	Зарцуулалт	Үлдэгдэл	1	Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062	1502	3060	2	Эргэлтийн хөрөнгө	2,923	2,923		3	Төв азийн зам		3,500			Нийт	10,985	7,925	3,060
№	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын Дүн (сан.төгрөг)	Төлөвлөгөө	Зарцуулалт	Үлдэгдэл																									
1	Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062	1502	3060																									
2	Эргэлтийн хөрөнгө	2,923	2,923																										
3	Төв азийн зам		3,500																										
	Нийт	10,985	7,925	3,060																									
	<p>1. Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт</p> <p>Экспортын тээврийн үйл ажиллагааг өргөжин тэлэхэд зориулж 2 цуваа буюу 100 ширхэг 13-6953 загварын тавцанг вагоныг ОХУ-аас худалдан авахаар төлөвлөсөн. Энэхүү төлөвлөгөө нь Төмөр замын тухай хуулийн хойшилж, мөн ОХУ-аас вагон худалдан авах үйл ажиллагаанд учирч буй саад бэрхшээлээс үүдэн вагоны хөрөнгө оруулалтын хугацаа, вагоны төрөлд өөрчлөлт оруулсан.</p> <p>Эхний 10 ширхэг 12-1293 загварын хагас вагон нь 2024 оны 11-р сард үйлдвэрээс монгол улсад ирсэн байна. Дараагийн 40 ширхэг вагон үйлдвэрт бэлэн болж Монгол улс руу ирэхэд бэлэн болсон байна.</p> <p>2024 онд нийт 50 ширхэг вагоны төлбөрт 8 тэрбум төгрөг төлснөөс 1,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулагдсан байна. Үлдэгдэл төлбөр вагон монгол улсад орж ирснээр төлөгдөхөөр байна.</p>																												
	<p>2. Эргэлийн хөрөнгийн санхүүжүүлэлт</p> <p>Охин компаниудын өсөлтийг хангахын тулд эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор 2,9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.</p>																												
	<p>3. Шинэ бизнес: М&А - Төв Азийн Зам ХХК</p>																												

	Монложистикс групп нь зах зээл дээр хэдийн байршсан компани худалдан авах замаар зах зээлд эзлэх байр сууриа тэлэхээр сүүлийн жилүүдэд хурдтай өсөж буй ТЭСО группийн охин компани болох Төв Азийн Зам ХХК-ний 51%-ийг худалдан авахад 3,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулагдсан байна.
9.	Ногдол ашгийн мэдээлэл
	<p>“Монложистикс Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн №25/ТУЗ/09 тоот тогтоолоор компанийн 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 21.9% /хорин нэг аравны ес/ хувь буюу 2,137,637,638.80 /хоёр тэрбум нэг зуун гучин долоон сая зургаан зуун гучин долоон мянга зургаан зуун гучин найман төгрөг наян мөнгө/ төгрөгийг Компанийн нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>Нэгж хувьцаа тус бүрд 5.4 /таван төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн ногдол ашиг хуваарилна.</p> <p>Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоон, ногдол ашгийг 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр “ҮЦГХТ” ХХК-аар дамжуулан олгоно.</p>
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	Үйл ажиллагааны тайлангийн Тогтвортой хөгжил бүлэгт тусгав.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
<p>Овог, нэр: Ц. Дуламсүрэн</p> <p>Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга</p> <p>Гарын үсэг: </p>	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2025-04-21	

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЖИЛИЙН ТАЙЛАН
2024 ОН

Агуулга

01 Бидний тухай

Компанийн тухай	4
Хуулийн этгээдийн мэдээлэл	5
Эрхэм зорилго, Алсын хараа	6
Үнэт зүйлс	7
Группийн бүтэц	9
Группийн түүхэн замнал	10
ТУЗ-ийн даргын мэндчилгээ	12
Группийн гүйцэтгэх захирлын захидал	14
Онцлох тоон үзүүлэлтүүд	15
Онцлох санхүүгийн үзүүлэлт	16
Онцлох тээвэр	19
Онцлох үйл явдал	20

02 Зах зээл ба компанийн стратеги

Дэлхийн тээвэр ложистикийн салбар	24
Монголын тээвэр ложистикийн салбар	25
Алсын хараа 2030	26
Бизнес модель	27
2030 стратеги	28
Санхүүгийн үзүүлэлт	30
Группийн гүйцэтгэл - Импорт	32
Группийн гүйцэтгэл - Экспорт	33
Группийн гүйцэтгэл - Транзит	34
Группийн гүйцэтгэл - Бусад	35
2025 оны зорилт болон хөрөнгө оруулалт	36

03 Тогтвортой хөгжил

Нийгэм ба байгаль орчин	38
Шамбала 2056 төсөл	38
Төмөр замын тээвэр	39
Нийгэм - Do Good Hub	40
Хүний нөөцийн бодлого	42
Өндөр чадвартай мэргэжлийн хамт олон	42
Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл	43
ESOP Хуримтлалын хөтөлбөр	45
KESO хөтөлбөр	45

04 Засаглал

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	48
Хувьцаа эзэмшигчдийн хурал	48
Төлөөлөн удирдах зөвлөл	49
ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан	50
Засаглалын зарчмуудын хэрэгжилт, өөрийн үнэлгээ, хянан баталгаажилт	52
Ил тод байдал, тайлагнал	52
Ногдол ашгийн бодлого	53
Гүйцэтгэх удирдлагын баг	54
Охин компаниудын удирдлага	55
Хувьцааны мэдээлэл	56
Хувьцаа эргүүлэн худалдаж авах мэдээлэл	56
Оролцогч талуудтай харилцах стратеги	58



05 Дотоод хяналтын тогтолцоо

Дотоод хяналтын тогтолцоо	60
Эрсдэлийн удирдлага	60
Нийцлийн удирдлага	61
Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл	61
Дотоод аудит	62
Шүгэл үлээх тогтолцоо	62
Группийн хэмжээнд хийгдсэн дотоод хяналтын тогтолцооны үнэлгээ	62
Хөндлөнгийн баталгаажуулалт	62

06 Санхүүгийн тайлан

Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	64
Нэгтгэсэн санхүү байдлын тайлан	64
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	65
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	66
Тайлагналын зарчим	67
Тайлбар толь	68



1

Бидний тухай

Үйл ажиллагааны тайлан 2024



КОМПАНИЙН ТУХАЙ

Монложистикс Групп нь 2005 онд тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өдгөө 1 толгой компани, 10 охин компани, 240 ажилтан, 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй Монгол улсын тээврийн салбарын тэргүүлэгч байгууллага болсон байна.

Монложистикс Групп нь Монгол Улсын иргэдийн өдөр тутам хэрэглэдэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уул уурхайн түүхийг эд бүтээгдэхүүнийг экспортлох, хөрш орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит, тракинг зэрэг тээвэр ложистикийн бүх төрлөөр олон улсын стандартад нийцсэн тээврийн цогц үйлчилгээг үзүүлсээр байна.

Монложистикс Холдинг ХК нь тээвэр ложистикийн цогц үйлчилгээ үзүүлэгч группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, тэдгээрт хүний нөөц, санхүү, мэдээллийн технологи, маркетинг, стратеги, бизнес хөгжил, ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлдэг толгой компани юм.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр:

Монложистикс Холдинг ХК

Хэлбэр:

Нээлттэй хувьцаат компани

Регистрийн дугаар:

6381251

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны чиглэл:

Менежментийн зөвлөх үйлчилгээ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:

Монголын Хөрөнгийн Бирж

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн индекс:

Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20

Монголын Хөрөнгийн Бирж дээрх симбол:

MSE:MLG

Утас:

+976 7701-5454

Имэйл:

info@mlholding.mn

Вэбсайт:

www.mlholding.mn

Фэйсбүүк хуудас: **Monlogistics Group**

Албан ёсны хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, Нью Хоризонс оффис, 1101 тоот



ЭРХЭМ ЗОРИЛГО

ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

АЛСЫН ХАРАА

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол Улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.





Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгүй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтээл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.



Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээгээрээ багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинийг санаачлагч багуудаас бүрдэнэ.



Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол Улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.



Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанид тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.




Шударга, ил тод байдал

Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.

ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

Үйл ажиллагааны тайлан 2024

ГРУППИЙН БҮТЭЦ



ГРУППИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Монголын Тээвэр зуучийн нэгдсэн холбоонд албан ёсны гишүүнээр элсэв.

2006 ОН



Монгол Улсын Гаалийн ерөнхий газраас Гаалийн зуучлагчийн тусгай зөвшөөрлийг авав.

2010 ОН

Олон улсын тээвэр зуучийн нэгдсэн холбоонд албан ёсны гишүүнээр элсэв.

2014 ОН

Rebranding “Upgrade 10” төслийг амжилттай эхлүүлэв.

2016 ОН

2005 ОН

Монлогистикс Ворлдвайд ХХК анхны ууган компани байгуулагдав.



2009 ОН

Төмөр замын аюулгүй ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүлээн авав.



2011 ОН

Монголын гаалийн зуучлагчдын нэгдсэн холбооны гишүүнээр элсэв.



2015 ОН

ISO 9001:2008 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэв.





Оюу толгой компанийн албан ёсны тээврийн компаниар шалгарав.



Монложистикс Холдинг ХХК
Толгой компани байгуулагдав.



Түүхий эдийн экспортын тээврийг эхлүүлж, Кauc Аустралис ХХК-ийг байгуулав.



CORE системийн шинэчлэл хийгдэв. Группт 3 шинэ охин компани нэмэгдэв.

2018 ОН

2020 ОН

2022 ОН

2024 ОН

2017 ОН

Бүх тээврийг даатгалд хамруулах үйлчилгээг нэвтрүүлэв.

2019 ОН

Монложистикс Транзит ХХК байгуулагдав.

2021 ОН

Портфолио өргөжилт хийж, 3 охин компаниа байгуулав.

2023 ОН

Монложистикс Холдинг ХХК Олон нийтэд нээлттэй компани болов.

Монложистикс Холдинг ХК Do good HUB ТББ-ыг байгуулав.



“

**СТРАТЕГИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ
АМЖИЛТТАЙ
ХЭРЭГЖИЖ, БИЗНЕСИЙН
ШИНЭ ОРОН ЗАЙД
ТЭЛЭЛТ ХИЙСЭН,
ҮЙЛ АЖИЛЛАГААГАА
ӨРГӨЖҮҮЛСЭН ЖИЛ
БАЙЛАА.**

”



ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын хувьд 2024 он нь тээвэр ложистикийн салбарт түүхэн дээд үзүүлэлтүүдийг дахин шинэчлэн тогтоосон бас нэгэн онцгой үр дүнтэй жил болж өнгөрлөө. Манай хамт олон тайлант хугацааны турш гүйцэтгэсэн тээврийн тоо хэмжээ, нийт борлуулалтыг багагүй хэмжээгээр өсгөж чадсанаар энэхүү өсөлтөд жинтэй хувь нэмэр оруулсан гэдгийг та бүхний сонорт хүргэхэд таатай байна. Бид салбарын тэргүүлэгчийн байр сууриа улам бататгах үүднээс үйл ажиллагаандаа нэвтрүүлэх инновац, шинэ техник технологийн судалгаа, эрэл хайгуулыг зогсолтгүй үргэлжлүүлж байна. Та бидний амьдарч буй өнөөдрийн цаг үед эрчимтэй өрнөж байгаа аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал, техник, технологийн үсрэнгүй хөгжлийг компанийн бүтээмжийг өсгөх онцгой ач холбогдолтой, бидэнд олдсон боломж хэмээн үзэж, группийн хэмжээнд хэрэгжүүлж буй цахим шилжилтийг хурдасган, хиймэл оюун ухааны хэрэглээг улам идэвхжүүлэхээр ажиллаж байна. Түүнчлэн, Монложистикс Группийн хувьд дэлхийн тээвэр, ложистикийн хамгийн том үзэсгэлэн, форумуудад амжилттай оролцож, олон улсын түвшинд хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн нь тээвэр ложистикийн салбарт төдийгүй Монгол Улсын худалдаа, эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулахуйц үйл явдал боллоо.

Дэлхийн зургаан тивд орших бидний байнгын түнш агентууд, олон жил хамтран ажиллаж байгаа мянга мянган үнэнч үйлчлүүлэгчид, бидэнд итгэл хүлээлгэсэн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нарын тууштай дэмжлэг нь манай хамт олонд цаашид хөгжин дэвших, үргэлж сайжрах урам зоригийг төрүүлэхээс гадна тэдний хүлээлтэд хүрч ажиллах өндөр хариуцлагыг бид гүнээ ухамсарлан ажиллаж байгаа гэдгээ та бүгддээ мэдэгдэхэд мөн таатай байна.

2025 онд компани үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан өнгөрсөн хугацааны түүхэн үзүүлэлтүүд, өсөлтийн динамикт анализ хийх, ололт амжилтаас гадна алдсан боломж, алдаа оноондоо дүгнэлт өгөх, мөн дараагийн хорин жилийн хөгжлийн стратегийг боловсруулах томоохон ажил бидний өмнө ирээд байна. Бид энэхүү түүхт ойн босгон дээр бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёлоор үлгэрлэж, олон улсын төвшинд нийцсэн чанартай үйлчилгээг та бүгддээ хүргэн илүү их үнэ цэн бүтээн улс нийгэм, эдийн засгийн хөгжилд өөрсдийн хувь нэмрээ оруулах урам зориг итгэлээр дүүрэн ажиллаж байгааг уламжилъя.

Хүндэтгэсэн,

Л.ГАНЗОРИГТ

ТУЗ-ИЙН ДАРГА, ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ



ГРУППИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

Хувьцаа эзэмшигчид, харилцагч үйлчлүүлэгчид, хамтран ажилладаг түнш байгууллагууд болон группийн нийт хамт олондоо 2024 оны жилийн эцсийн тайлангаараа дамжуулан бидний үйл ажиллагааг тууштай дэмжиж, итгэл хүлээлгэн хамтран ажилласанд чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Өмнөх 18 жилийн адилаар 2024 он Монложистикс Группийн хувьд ажил ундарсан, өсөлт үргэлжилсэн, ирээдүй рүү тэмүүлсэн бас нэгэн амжилттай жил болж өнгөрснийг та бүхэндээ дуулгахад бахархалтай байна. Өнгөрөгч 2023 онтой харьцуулахад Монложистикс Группийн хэмжээнд нийт 1.1 сая тонн ачаа тээвэрлэж 8 хувь, нийт борлуулалтын орлого 297 тэрбум төгрөгт хүрч 41 хувь, нийт цэвэр ашиг 10.3 тэрбум төгрөг буюу 24 хувь тус тус өсөж, 23 хувийн эздийн өмчийн өгөөжийн гүйцэтгэлтэй ажиллалаа. Энэхүү үр дүн нь группийн хамт олон, нийт Монложистиксчуудын эрч хүч, хүчин чармайлт, тууштай хөдөлмөрийн үр дүн байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Тээврийн үндсэн үйл ажиллагаанаас гадна Монгол Улсын Засгийн Газраас баримталж буй экспортыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийг дэмжих бодлого, чиглэлд нийцүүлэн бид бүхний дэвшүүлсэн урт хугацааны стратеги төлөвлөгөөний хүрээнд ОХУ-д захиалан үйлдвэрлүүлсэн цоо шинэ вагонуудын эхний ээлжийг хүлээн авч, тээвэрлэлтэнд оролцуулж эхэлсэн нь төмөр замын экспортын үйлчилгээг төгөлдөржүүлэхийн хажуугаар группийн үйл ажиллагаанд олон эерэг нөлөө, ахиц дэвшлийг авчрах үйл явдал боллоо. Түүнчлэн тээврийн салбарын хамгийн анхны M&A буюу нэгдэх, худалдан авах үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэж, чадварлаг хамт олонтой, онцгой бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэдэг Төв Азийн Зам ХХК-ийг группийн бүрэлдэхүүнд нэгтгэж чадлаа.

Мөн урт хугацааны тогтвортой өсөлтийн стратегийн хүрээнд Logistics Management System (LMS) болон Enterprise Resource Planning (ERP) зэрэг зөөлөн дэд бүтцийн чухал системүүдийг бүрэн шинэчилж, ирээдүйд олон дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн нь харилцагч үйлчлүүлэгчиддээ үнэ цэнийг бий болгох том алхам боллоо. Группийн

бүх компаниуд ISO 9001:2015 олон улсын чанарын удирдлагын тогтолцоог амжилттай нэвтрүүлж, агаарын тээврийн Монложистикс Экспресс ХХК-ийн үйл ажиллагааг эхлүүлж, олон улсын хоёр дахь охин компаниа БНХАУ-ын Тяньжин хотод үүсгэн байгуулж, БНХАУ-ын төрийн өмчит Төмөр Замын Корпорацитай иж бүрэн стратегийн хамтын ажиллагааны гэрээг байгуулсан нь бид бүхний 2024 оны хамтын ололт амжилтыг бэлхнээ илэрхийлж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Өнгөрсөн 3 жилийн хугацаанд Монгол Улсын нийт ДНБ болон нэг хүнд ногдох ДНБ түүхэн дээд хэмжээнд хүрэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн тээвэр ложистикийн салбар цаашид ч мөн улс орны хөгжлийн чухал хөдөлгөгч хүч байна гэдэгт итгэлтэй байна. Хэдийгээр урт хугацааны түүхий эдийн ханшийн уналт, дэлхийн худалдааны тодорхой бус байдал, хойд хөршийн улс төрийн зөрчилдөөн зэрэг олон бэрхшээл, сорилтууд бидэнд тулгарч байгаа боловч тээвэр ложистикийн салбарын инновац, дэд бүтцийн өргөжилт болон өндөр бүтээмжтэй тээврийн шийдлээр бид өөрсдийн нийт экспортыг биет хэмжээгээр нэмэгдүүлж, импортын өртгийг бууруулж, дамжин өнгөрөх транзит тээврийг нэмэгдүүлснээр эдийн засгийн өсөлтийг үргэлжүүлэх боломж бүрдэнэ гэж харж байна. Энэхүү чухал цаг мөчид олон талт хүчин чармайлтад Монложистикс Группийн нийт хамт олон урьдын адил хувь нэмрээ оруулж, манлайлж оролцох болно.

Тиймээс ирж буй 2025 онд Монложистикс Групп үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн босгон дээр олон томоохон ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд “Алсын Хараа 2030” урт хугацааны зорилгодоо хүрэхэд дахин нэг том алхмыг хийхээр бид зорьж байна. Вагонуудаа төмөр замын тээврийн үйл ажиллагаанд бүрэн оролцуулсан, Тяньжин дахь охин компанийн үйл ажиллагааг улам өргөжүүлсэн, томоохон төсөл хөтөлбөрүүдийн судалгаа шинжилгээ болон суурийг тавьж, дэвшилтэт технологиудыг үйл ажиллагаандаа бодитоор нэвтрүүлсэн зэрэг олон сайн мэдээтэй та бүхэнтэйгээ дахин уулзана гэж итгэж байна.

Хүндэтгэсэн,

Г. ХИШИГБАТ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Борлуулалтын орлогын өсөлт

^ **+41%**

Цэвэр ашгийн өсөлт

^ **+24%**

Цэвэр ашиг

10.3 тэрбум төгрөг

Эздийн өмчийн өгөөж /ROE/

23%

Нийт татвар төлөлт

26 тэрбум төгрөг

Онцлох үйл явдал



**Төв Азийн Зам ХХК-г
НЭГТГЭВ**

ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2022	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2023	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2024	Өсөлт (бууралт)
ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ	мян.кг	395.84	1,042.33	1,124.65	8%
ОРЛОГЫН ҮР ДҮН					
Борлуулалтын орлого	сая.төг	136,095	210,361	296,858	41%
Нийт ашиг	сая.төг	16,547	18,108	24,381	35%
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	11,419	9,290	12,695	37%
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая.төг	9,392	8,363	10,346	24%
БАЛАНС					
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	39,725	54,577	82,080	50%
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	2,372	3,031	10,275	239%
Нийт хөрөнгө	сая.төг	42,097	57,609	92,355	60%
Нийт өр төлбөр	сая.төг	16,959	14,169	43,705	208%
Нийт эздийн өмч	сая.төг	25,138	43,439	48,650	12%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	42,097	57,609	92,355	60%
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ					
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	9,382	4,480	(13,598)	-404%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(1,232)	(2,390)	(14,462)	505%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(492)	6,037	15,142	151%
Бусад мөнгөн гүйлгээ	сая.төг	725	(203)	(495)	143%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	8,383	7,924	(13,413)	-269%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	5,816	14,198	22,122	56%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	14,198	22,122	8,709	-61%
ТАТВАР ТӨЛӨЛТ					
НӨАТ	сая.төг	2,820	3,152	9,270	194%
ААНОАТ	сая.төг	1,385	1,275	1,960	54%
Гаалийн татвар	сая.төг	-	-	2,705	-
Онцгой албан татвар	сая.төг	-	-	12,011	-
Нийт татвар төлөлт	сая.төг	4,205	4,427	25,946	486%

ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Харьцаа үзүүлэлтүүд

Санхүүгийн харьцаа үзүүлэлт Financial ratio		2022	2023	2024
Нийт ашгийн хувь Gross margin	хувь	12.2%	8.6%	8.2%
Цэвэр ашгийн хувь Net margin	хувь	6.9%	4.0%	3.5%
Өөрийн хөрөнгийн өгөөж Return on equity	хувь	37%	19%	22%
Өөрийн хөрөнгийн харьцаа Solvency ratio	хувь	69%	51%	52%
Үйл ажиллагааны эргэц Operation cycle	хоног	87.65	71.94	48.17
Эргэлтийн харьцаа Current ratio	нэгж	2.37	3.98	2.20
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа Cash ratio	нэгж	2.01	3.43	1.36
Хувьцааны харьцаа үзүүлэлт Share ratio		2022	2023	2024
Нэгж хувьцаанд ногдох ашиг Earnings per share	төгрөг	359,542.55	14.97	18.54
Эргэлтэнд байгаа хувьцаа Number of shares issued **	ширхэг	22,432	395,858,822	395,858,822
Хувьцааны хаалтын ханш Share price at year-end ***	төгрөг	4,358.45	180.39	185.00
Зарласан нэгж хувьцаанд ногдох ашиг Proposed dividend per share	төгрөг	-	7.58	5.40

** 2023 онд хувьцаат компани болохтой холбогдуулан нэгж хувьцааг 15000 ширхэг болгон хувааж, нэмж 59,378,822 ширхэг хувьцаа нэмж гаргасан

*** 2021, 2022 оны хувьцааны хаалтын ханш нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн сангийн нэрлэсэн үнэ



ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

Үйл ажиллагааны тайлан 2024

ОНЦЛОХ ТЭЭВЭР

Монложистикс Тракинг ХХК

Монложистикс Тракинг ХХК нь 2024 оны 8-р сараас эхлэн транзит тээврийн үйл ажиллагаагаа өргөжүүлэн Азийн авто замын сүлжээний АН-4 чиглэлийн авто замаар БНХАУ-ын Такашкен боомтоос ОХУ-ын Ташанта боомтоор дамжуулан, ОХУ-ын Москва хот руу тогтмол транзит тээвэр зохион байгуулж эхэллээ.



Монложистикс Ворлдвайд ХХК

Херо Энтертайнмент Групп ХХК-ийн захиалгаар Монгол Хаан жүжгийн тайз болон туслах хэрэглэлийг Монгол Улсаас Сингапур улс руу агаараар, мөн уран бүтээлч Э.Жанцанхоролын Malca-Amit Fine art бүтээлүүдийг тусгай тээвэрлэлтийн горимоор амжилттай тээвэрлэлээ.

Монложистикс Тракинг ХХК болон Монложистикс Ворлдвайд ХХК

Монложистикс Группийн охин компаниуд хамтран БНХАУ-ын Эрээн хотоос Монгол Улсын Эрдэнэт хотын чиглэлд өргөн, өндөр, хэтрүү овортой ачааг / FLSmidth-n/ цуваагаар зохион байгуулж амжилттай тээвэрлэлээ.



Монложистикс Ворлдвайд ХХК

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл шинэчлэлийн төслийн ачаа болох трансформатор тоног төхөөрөмжийг тээвэрлэлээ. Тус тээвэр нь эмзэг, доргилт мэдрэгч суурилуулсан, хурдны хязгаар заасан онцлогтой ачаа байлаа.

Монложистикс Ворлдвайд ХХК

Монложистикс Ворлдвайд ХХК нь 2024 оны 11-р сараас эхлэн Монгол Улсын Засгийн Газар болон АНУ-ын Мянганы Сорилтын Корпорац хооронд байгуулсан Компакт гэрээний хүрээнд Улаанбаатар хотын ус хангамжийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн ачааг тээвэрлэж эхэллээ.



Монложистикс Ворлдвайд ХХК

Монложистикс Ворлдвайд ХХК 2024 оны 11-р сард Тесо группийн охин компани болох Айсмарк ХХК-ийн зайрмагийн үйлдвэрийн шинэ тоног төхөөрөмжүүдийг амжилттай тээвэрлэж авчирлаа.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Монложистикс Групп хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт хийж, эхний ээлжийн вагонуудаа амжилттай хүлээн авлаа.

Монложистикс Групп нь бизнесийн үр ашгаа нэмэгдүүлэх, өрсөлдөөний давуу талуудыг бий болгох зорилгоор дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт хийх IPO-н төлөвлөгөөний дагуу ОХУ-аас худалдан авсан эхний ээлжийн вагонуудаа 2024 оны 12-р сард амжилттай хүлээн авсан бөгөөд дараагийн ээлжийн 40 ширхэг вагоныг удахгүй хүлээн авна. Өөрийн хөдлөх бүрэлдэхүүнтэй болсноор Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтэд хувь нэмрээ оруулах, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтэд оролцох, Монложистикс Группийн борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.



Монложистикс Групп Төв Азийн Зам ХХК-ийг өөртөө нэгтгэлээ.

Монложистикс Групп тээвэр ложистикийн салбарт өөрийн үйл ажиллагаа, бизнесийн цар хүрээгээ тэлж, ТЭСО Группийн охин компани болох “Төв Азийн Зам” ХХК-ийн хувьцааг худалдан авах, хөрөнгө оруулах замаар хяналтын багц буюу 51 хувийг өөртөө нэгтгэлээ.

Монгол Улсын нийт импортын 20 хувийг дангаараа бүрдүүлдэг суудлын автомашины зах зээлд томоохон байр суурь эзэлдэг мэргэжлийн хамт олонтой Төв Азийн Зам ХХК-ийг өөртөө нэгтгэснээр группийн борлуулалтын орлого 15%-20%, хүлээгдэж буй цэвэр ашиг 10%-15%-аар нэмэгдлээ.

“Logistic Management System” болон “Odoo ERP version 17”-г амжилттай нэвтрүүлээ.

Монложистикс Групп бүрэн дижитал шилжилт хийх урт хугацааны зорилтот стратегийн хүрээнд дотооддоо хөгжүүлэлт хийсэн LMS /Logistic Management System/ төслийн анхны “LMS 1.0” хувилбарыг 2024 оны 6-р сард амжилттай нэвтрүүлээ.

Группийн үндсэн болон дэмжих үйл ажиллагааг автоматжуулах “Odoo ERP V.17” хувилбарыг ахиулан гар утасны аппликейшнтэй болгон мөн онд нэвтрүүлээ.

Бид цаашид үйл ажиллагаандаа орчин цагийн програм хангамж, хиймэл оюун ухааныг шат дараатай нэвтрүүлж, ложистикийн үйлчилгээг дараагийн төвшинд хүргэх зорилт тавин ажиллаж байна.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Монложистикс Групп агаарын тээврийн салбарт үйл ажиллагаагаа өргөжүүлээ.

Монложистикс Экспресс ХХК нь агаарын тээврийн үйлчилгээг шуурхай, найдвартай үзүүлэх зорилгоор B2B болон B2C сегментэд чиглэсэн олон улсын агаарын тээврийн зуучлал, олон улсын буухиа шуудангийн үйлчилгээг 2024 оны 8-р сараас эхлүүлээд байна. Гадаад худалдаа, цахим худалдааны эрчимтэй өсөлтийг дэмжиж, үйлчлүүлэгчдэдээ илүү өргөн боломж, хялбар шийдлүүдийг санал болгохын төлөө Монложистикс Экспресс ХХК нь агаарын тээврийн сүлжээг өргөжүүлж, олон улсын зах зээлд өрсөлдөхүйц ложистикийн цогц үйлчилгээ үзүүлэхээр зорин ажиллаж байна.



Монложистикс Групп ISO 9001:2015 гэрчилгээгээ гардан авлаа.

Монложистикс Групп 2024 оны стратегийн зорилтын хүрээнд үйлчилгээний чанарын соёлыг сайжруулах ажлыг амжилттай хэрэгжүүлж, ISO 9001:2015 олон улсын чанарын удирдлагын тогтолцоог группийн хэмжээнд нэвтрүүллээ. 2024 оны 11-р сард группийн бүрэлдэхүүнд багтдаг нийт зургаан компани олон улсын баталгаажуулалтын аудитад амжилттай хамрагдаж, үл тохиролгүй, зөрүүгүй үнэлгээтэйгээр тэнцэж, Австралийн TQCS International PTY LTD байгууллагаас ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээг албан ёсоор гардан авлаа. TQCSI олон улсын аудит, баталгаажуулалтын байгууллага нь жил бүр үйл ажиллагаа явуулж буй улс орон бүрээсээ нэг шилдэг харилцагчийг онцлон тодруулдаг бөгөөд 2024 онд Монгол Улсын “Шилдэг харилцагч”-аар Монложистикс Холдинг ХК нэрлэгдлээ.



Монложистикс Групп салбарын шилдэгээр шалгарлаа.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас уламжлал болгон зохион байгуулдаг оны шилдэг аж ахуйн нэгж, салбарын шилдгүүдийг шалгаруулдаг “Entrepreneur 2024”-ийн “Тээвэр ложистикийн Entrepreneur” шагналыг Монложистикс Групп 2 дахь удаагаа хүртэж, салбартаа манлайлагч, шилдэг энтрепренер байгууллага болохоо дахин баталлаа.

УБТЗ ХНН-ийн үйлчлүүлэгч нарын зөвлөгөөн 2024 оны 3-р сард болж, Монложистикс Транзит ХХК-ийг “Шилдэг транзит тээвэр зууч байгууллага”-аар шалгаруулсан.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



БНХАУ-ын төмөр замын байгууллагатай хамтын ажиллагааны гэрээг байгууллаа.

Монложистикс Холдинг ХК нь China State Railway Group корпорацийн охин компани болох China Railway International Multimodal Transport Co.Ltd.-тэй олон талт стратегийн хамтын ажиллагааны гэрээг байгууллаа. Уг гэрээг байгуулснаар Монложистикс Групп нь БНХАУ-ын төрийн өмчит төмөр замын байгууллагатай илүү нягт хамтран ажиллаж, импорт, экспорт, транзит тээвэр хийж гүйцэтгэх мөн дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдэд хамтран хөрөнгө оруулах боломжууд нээгдэж байна.



“Хөрөнгө оруулагчидтай харилцах” зөвлөх үйлчилгээг авлаа.

Монложистикс Холдинг ХК нь олон нийтэд нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчид болон хөрөнгийн зах зээлийн нийт оролцогчдод мэдээллээ илүү нээлттэй, ил тод, хүртээмжтэй хүргэж, оролцогч талуудтай хэрхэн зөв харилцаатай байх тал дээр онцгой анхааран ажиллаж байна. Хөрөнгө оруулагчидтай харилцах (Investor Relation) функцээ сайжруулах зорилгоор Монложистикс Холдинг ХК нь мэргэжлийн судалгаа, зөвлөх үйлчилгээний компани болох СММ Коммуникаци ба Адвайзорийс ХХК-тай хамтран ажиллаж, төлөвлөгөөт олон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



MSE TOP 20 index

Монложистикс Холдинг ХК нь 2023 оны 9-р сард анхдагч хувьцаагаа гаргаж олон нийтэд нээлттэй компани болсон. Монголын хөрөнгийн биржийн 2024 оны 1-р сард шинэчлэгдсэн ТОП-20 индексд тээвэр, ложистикийн салбарыг төлөөлж орсон онцлох үйл явдал болсон. Монложистикс Холдинг ХК нь арилжааны идэвхи болон компанийн зах зээлийн үнэлгээгээр ТОП-20 индексээ хэвээр хадгалсаар байна.



Бизнес арга хэмжээ

БНХАУ-ын Шанхай хотод 2024 оны 6-р сард зохион байгуулагдсан дэлхийн тээвэр ложистикийн салбарын хамгийн том үзэсгэлэн, форум болох “Transport Logistic-2024” арга хэмжээнд Монложистикс группийн 4 компанийн төлөөлөл амжилттай оролцлоо. Монложистикс Группийн удирдлагууд Бүгд Найрамдах Узбекистан Улс руу 2024 оны 11-р сард аялж, тус улсын тээвэр ложистикийн салбарт үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг судласан бизнес аялал зохион байгууллаа.



2

Зах зээл ба компанийн стратеги


Үйл ажиллагааны тайлан 2024

ДЭЛХИЙН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН САЛБАР

Өнөөгийн байдал

Дэлхийн тээвэр ложистикийн зах зээлийн хэмжээ 2024 онд 10 их наяд ам.долларт хүрсэн бөгөөд цаашид 2033 он гэхэд 22 их наяд ам.доллар болж 2 дахин өсөх төлөвтэй байгаа юм. Өөрөөр хэлбэл тээврийн салбарын жилийн нийлмэл өсөлтийн хувь (CAGR) нь дунджаар 9.35% байхаар байна. Гэвч АНУ, Европ, БНХАУ зэрэг томоохон эдийн засгуудыг хамарсан худалдааны дайн хурцадмал байдалд орсноос үүдэн худалдааны тариф нэмэгдэж, улс орнуудын бараа эргэлт саарах, дотооддоо үйлдвэрлэх, нөгөөтэйгүүр тариф багатай улс орнуудтай хийх гадаад худалдааны хэмжээгээ нэмэгдүүлэх, үйлдвэрүүдээ өөр улс орон руу нүүлгэх гэх мэт томоохон хөдөлгөөнүүд ажиглагдаж эхэллээ.

Дэлхийн ложистикийн салбарын зах зээл 2023 - 2033 /Usd trillion/



<https://www.precedenceresearch.com/logistics-market>



Ирээдүйн хандлага

Бүхий л салбарын ирээдүйн чиг хандлагыг бүхэлд нь өөрчлөхүйц дижитал шилжилтийн эрин үе тээвэр ложистикийн салбарыг ч мөн шинэ түвшинд гаргаж байна. Хиймэл оюун ухаан (AI), IoT зэрэг технологийн тусламжтай тээврийн маршрут төлөвлөх, тусгай ачаа барааг бодит цагт хянах зэрэг шинэ боломжууд бий болсноор түлш хэмнэх, ачаа хүргэлтийн хугацааг бууруулах, ачаа бараа гэмтэлгүй хүргэгдэх гэх мэт олон талын эерэг нөлөөг бий болгохоор байна. Монложистикс Группийн хувьд ч мөн үйл ажиллагааны стратегиа энэ чиглэлд тодорхойлж, дижитал шилжилтийн суурийг амжилттай тавьсан жил боллоо. Тухайлбал, тээврийн бүртгэлийн систем (LMS 2.0), нэгдсэн нөөцийн төлөвлөлтийн систем (ERP), өгөгдлийн нэгдсэн сан (DWH) зэрэг голлох төслүүдийг хэрэгжүүлж, байгууллагын мэдээллийн урсгал, удирдлагын үр ашигтай шийдвэр гаргалтанд томоохон ахиц гаргалаа.


Үүнээс гадна ухаалаг, жолоочгүй тээврийн хэрэгсэл буюу өөрөө явагч машинуудыг Tesla, Waymo, DHL гэх мэт компаниуд үйл ажиллагаандаа туршиж, зах зээлд нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна. Энэхүү инновацийн шийдлүүд тээврийн салбарт амжилттай нэвтэрснээр хүний хүчин зүйлээс хамаарсан ослын тоо буурах, зардал багасах, ажлын цагийг уртасгах гэх мэт салбарын өсөлтөд шууд чухал нөлөө үзүүлэхүйц боломжууд бий болох нь дамжиггүй юм.

Мөн технологийн дэвшил салбарын үйл ажиллагаанд нэвтрэхийн хэрээр тогтвортой хөгжлийн зорилт буюу байгаль орчинд ээлтэй шийдлүүдийг дэлхийн улс орнууд чухалчилж авч үзэх болов. Цахилгаан болон сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг тээврийн хэрэгсэл, агуулах зэргийг хөгжүүлж, байгальд үзүүлэх хор нөлөөг бууруулах санаачлагад DHL, FedEx гэх мэт компаниуд манлайлж, эрчимтэй хөрөнгө оруулалт хийж эхлээд байна. Бидний хувьд цаашид процессын автоматжуулалт (RPA), баримт бичгийн менежментийн систем (DMS), хиймэл оюун ухаанд суурилсан тээврийн маршрут, үнэ тооцох зэрэг төслүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлж, цаасны хэрэглээг бууруулах, байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөг арилгахад анхаарч, үйл ажиллагааг илүү түргэн шуурхай, хэмнэлттэй болгоход чиглүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН САЛБАР

2024 онд Монгол Улсын хэмжээнд хамгийн өндөр өсөлтийг тээвэр ложистикийн салбар үзүүлж, 23 хувьд хүрсэн нь ДНБ-ий 7 хувийг эзлэх боллоо. Үүний дотор экспортын ачааны хэмжээ 20 хувиар нэмэгдэж, импортын ачааны эргэлт 19 хувиар тус тус өссөн бөгөөд цаашдын жилүүдэд ч мөн өсөх хандлага ажиглагдаж байна. Учир нь Монгол Улсын Засгийн Газраас дэвшүүлсэн “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө болон “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөгөөнүүдэд тусгагдсан дэд бүтцийн бүтээн байгуулалтууд, тэр дундаа Гашуунсүхайд - Ганцмод, Шивээхүрэн - Сэхэ, Бичигт - Зүүн хатавч зэрэг Монгол Улс БНХАУ-ыг холбосон хил дамнасан төмөр зам болон автозамын холболтууд, бүсчилсэн хөгжлийн төслүүд урт хугацаанд саатсан гацаанаас гарч, хөрш орнуудтай тохиролцоонд хүрч чадсанаар Монгол Улсын тээвэр ложистикийн сүлжээ өргөжиж, бүс нутгийг холбосон шинэ гарцуудыг бий болгох юм. Монложистикс Группийн хувьд энэхүү шинэ боломжуудыг ашиглахад чиглэгдсэн хөрөнгө оруулалтуудыг 2024 онд нэмэгдүүлсний нэг нь 50 ширхэг ачааны хагас вагон шинээр худалдан авч группийн хэмжээнд анхны төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний баазыг бий болгосон явдал байв. Түүнээс гадна ачаа эргэлтийн өртгийг нэмэгдүүлж, хугацааг уртасгах гол хүчин зүйл болоод байгаа терминалын үйл ажиллагаа, хүчин чадлыг сайжруулахад чиглэсэн томоохон ажлуудын эхлэлийг тавьж чадсан жил боллоо.

Салбаруудыг өмнө жилийн мөн үетэй харьцуулсан өсөлт, бууралт



Эх сурвалж: www.1212.mn



АЛСЫН ХАРАА 2030

Бид орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж улмаар Монгол Улсыг Ази, Европыг холбосон ложистик төв болгоно.


Уг алсын харааг биелүүлэх урт хугацааны стратеги, зорилгын хүрээнд дараах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.



БИЗНЕС МОДЕЛЬ

Олон улсад нийлүүлэлтийн сүлжээг удирдах хэлбэр 1PL загвараас 5PL хүртэл хөгжөөд буй бөгөөд Монложистикс Группийн хувьд өөрийн харилцагч байгууллагуудын ачааг тээвэрлэх тээврийн шинэ маршрутыг хөгжүүлснээр геополитикийн хүндрэлээс үүсэж буй тээвэрлэлтийн хүндрэл бэрхшээлийг даван туулах, хамтран ажиллагч түншийн харилцаа болон дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлснээр тээвэрлэлтийн хямд бөгөөд хурдан шуурхай үйлчилгээг санал болгож, өөрийн 3PL бизнес моделийг хөгжүүлэн ажиллаж байна.

3PL загвар нь ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний олон асуудлыг хариуцдаг мэргэжлийн ложистикийн үйлчилгээ үзүүлэгч компаниас Ачааг хүлээн авах, Тээвэрлэх, Хадгалах, Савлах, Шошголох, Хүргэлт хийх гэх мэт үйлчилгээг авч байгаа хэлбэр юм. 3PL үйлчилгээ үзүүлэгчид нь илгээгч болон тээвэрлэгчдийн хооронд зохион байгуулагчийн үүрэг гүйцэтгэж, үр ашгийг оновчтой болгох, зардлыг бууруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд нийлүүлэлтийн гинжин хэлхээний ложистикийг удирддаг. 3PL үйлчилгээ үзүүлэгч компаниудын үйлчилгээг ашигласнаар бизнес эрхлэгчид үндсэн бизнестээ анхаарлаа төвлөрүүлж, ложистикийн хэрэгцээгээ туршлагатай мэргэжилтнүүдэд даатгаж чаддаг.



Бидний хувьд ачаа илгээгчээс хүрэх эцсийн цэг буюу ачаа хүлээн авагчид очих хүртэл тээвэр, ложистикийн бүхий л үйлчилгээг харилцагчдадаа санал болгодог. Үүнд тээврийн захиалга хүлээн авах, ачаа барааг илгээгчээс хүлээн авахаас өгсүүлээд агуулахын үйлчилгээ, баримт бичиг гаалийн бүрдүүлэлт хийх, ачааг тээврийн хэрэгсэлд ачих, бэхлэх, нэг тээврийн хэрэгслээс нөгөөд шуурхай шилжүүлэн ачих гэх мэт цогц үйлчилгээ багтдаг. Түүнчлэн олон улсад тээвэр ложистикийн үйл ажиллагаа эрхэлдэг нэр хүндтэй, туршлагатай түншүүдтэй хамтран эдгээр цогц үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ бүх ачааг эрсдэлээс хамгаалж, даатгалд хамруулдаг нь бидний давуу тал, онцлог юм.

Тээврийн цогц үйлчилгээ

Тээврийн захиалга авах – Ачаа барааг хүлээн авах – Агуулахад хадгалах – Баримт бичиг болон гаалийн бүрдүүлэлт хийх – Ачаа барааг бэхлэх – Худалдан авалтын менежмент – Тээврийн хэрэгсэл хооронд шуурхай шилжүүлэн ачих – Даатгал

A
Ачаа илгээгч



Эхний цэгээс эцсийн цэг хүртэлх ложистикийн цогц үйлчилгээ


Бид дэлхий даяар үйл ажиллагаа явуулж буй олон улс дах түншүүдтэйгээ хамтран ачаа илгээгчээс ачаа хүлээн авагч хүртэлх тээврийн өргөн сонголт бүхий цогц үйлчилгээг үзүүлдэг. Мөн бид өөрсдийн үйлчилгээний байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөлд анхаарлаа хандуулахын зэрэгцээ үйл ажиллагааны оновчтой байдлыг чухалчилдаг.



Тээвэрлэгчийн гэрээт туслан гүйцэтгэгч



B
Ачаа хүлээн авагч



Ложистикс болон түгээлтийн үйлчилгээ

Агуулахад хадгалах — Боож, баглах — Шилжүүлэн ачих — Хаягжуулалт, угсралт, шалгалтыг хийж гүйцэтгэх — Гаалийн бүрдүүлэлт — Баримт бичиг — Нийлүүлэлтийн гинжин хэлхээг оновчтой зохион байгуулах — 4PL



2030 СТРАТЕГИ

Монложистикс Группийн бүтэц зохион байгуулалтын хүрээнд өсөлтийн 4 стратеги, тогтвортой хөгжлийн 4 стратегийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



monlogistics

ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

Үйл ажиллагааны тайлан 2024

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2024 онд Монложистикс Группийн хувьд тээврийн хэмжээ 8%, борлуулалтын орлого 47%, цэвэр ашиг 24%-аар тус тус өсөж, тайлант хугацаанд зорилтот хөрөнгө оруулалтуудыг өмчийн болон өрийн хэрэгслүүдээр санхүүжүүлж, өөрийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилго тавин ажилласнаар бодит үр дүн гарсан жил болж өнгөрлөө.

Нэгтгэсэн орлогын тайлан

Орлогын тайлангийн үзүүлэлт (сая.төг)	2022	2023	2024	Өсөлт
Борлуулалтын орлого	136,095	210,361	296,858	41%
Борлуулалтын өртөг	(119,548)	(192,253)	(272,477)	
Нийт ашиг	16,547	18,108	24,381	35%
Борлуулалт, Удирдлагын зардал	(6,244)	(8,482)	(11,191)	32%
Бусад орлого	1,455	(35)	755	
Бусад зардал	(344)	(289)	(1,271)	
Үйл ажиллагааны цэвэр ашиг	11,415	9,302	12,695	36%
Санхүүгийн орлого (зардал)	(385)	283	(749)	
Татварын өмнөх цэвэр ашиг (ЕВТ)	11,029	9,585	11,946	25%
ОАТ-н зардал	(1,642)	(1,222)	(1,600)	
Цэвэр ашиг	9,387	8,363	10,346	24%

Орлогын тайлан

Монгол Улсын тээврийн салбар түүхэн дээд амжилтад хүрсэн 2024 онд Монложистикс Групп мөн адил түүхэн дээд борлуулалт болон цэвэр ашигтай ажиллалаа.

Борлуулалтын орлого бидний хүлээлтийн дагуу өмнөх оны мөн үеэс 41%-аар өсч, нийт 300 орчим тэрбум төгрөгт хүрсэн байна. Гэсэн хэдий ч, оны эхний хагас жилийн цэвэр ашиг хүлээлтээс доогуур гарсан нь тээврийн зах зээлийн өрсөлдөөн болон төмөр замаар гүйцэтгэсэн экспортын тээвэр төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйтэй холбоотой байв.

Борлуулалтын орлогыг сегмент бүрээр харуулбал:

Тээврийн тоо хэмжээ (мян.тн)	2022	2023	2024	эзлэх хувь	өсөлт
Импорт	111.1	90.3	91.6	8%	1%
Экспорт	68.4	157.3	168.6	15%	7%
Транзит	203.2	768	827.8	74%	8%
Бусад	13.2	26.7	36.6	3%	37%
Нийт	395.8	1,042.3	1,124.7	100%	8%

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Борлуулалтын орлого (сая.төг)	2022	2023	2024	эзлэх хувь
Импорт	102,546	84,286	165,995	54%
Экспорт	7,122	24,638	26,216	9%
Транзит	21,553	87,942	95,648	31%
Бусад	8,383	18,046	18,514	6%
Нийт	139,605	214,912	306,373	100%
Тохируулах бичилт	(3,510)	(4,551)	(9,515)	
Нийт	136,095	210,361	296,858	

Монложистикс Группийн орлогын бүрдэл дараах 3 хэсгээс бүрддэг.

Тээврийн үнэ: 2024 оны эхэнд, өмнөх гурван жилийн турш үргэлжилсэн тээврийн хүндрэлүүд арилж, нөхцөл байдал харьцангуй тогтворжсон нь тээврийн өртөг буурахад нөлөөлсөн. Харин жилийн дунд үеэс импортын ачаа эрс нэмэгдэж, Тяньжин боомт болон дотоодын терминалуудын хүчин чадлын хязгаарлалт үүссэнтэй холбоотойгоор тээврийн хугацаа удааширч, үүний улмаас тээврийн үнэ дахин өсөх хандлагатай болсон байна.

Ханш: 2024 оны ам.долларын ханш оны эхнээс 0.2% өссөн, мөн түүнчлэн дундаж ханш 3390₮ байсан нь группийн таамаглаж байсан хэмжээнээс бага байна.

Тээврийн хэмжээ: Тээврийн хэмжээ өнгөрсөн оноос 8% өссөн байна.

Нийт ашгийн маржин	2022	2023	2024
Импорт	11.3%	9.6%	8.0%
Экспорт	19.4%	6.8%	6.5%
Транзит	12.2%	7.5%	7.8%
Бусад	11.6%	9.9%	5.3%
Нийт	12.2%	8.6%	8.2%

Цэвэр ашиг: Групп 2024 онд өсөлтийн стратегийн хүрээнд шинэ компани байгуулж, бизнесийн нэгтгэл хийсэн. Үүний үр дүнд үйл ажиллагааны зардал 32%-иар нэмэгдсэн хэдий ч, бизнесийн нэгдэл болон импортын тээврийн өсөлт нь цэвэр ашгийг 24%-иар нэмэгдүүлэхэд голлон нөлөөлсөн байна.

Мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлт (сая.₮)	2022	2023	2024
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,382	4,480	(13,598)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(994)	(2,390)	(14,462)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(730)	6,037	15,142
Валютын ханшийн зөрүү	724	(203)	(495)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,383	7,924	(13,413)
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	5,816	14,198	22,122
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	14,198	22,122	8,709

- Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ -13.5 тэрбум төгрөг байна. Группийн нэгтгэлд шинээр орж ирсэн компаниудын нөлөөгөөр үйл ажиллагааны үзүүлэлтүүдэд өөрчлөлт орж байна. Групп нь шинээр автомашины тээвэр болон борлуулалт үйл ажиллагаанаас хамааран бараа материал, авлага нэмэгдсэнээр үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ буурах нөлөө үзүүлсэн байна.
- 2024 онд эхний ээлжийн вагон худалдан авалт болон Монложистикс Группийн авто машины парк шинэчлэлттэй холбоотой хөрөнгө оруулалтын зориулалттай мөнгөн гүйлгээ гаргасан. Мөн 2023 онд стратегийн хөрөнгө оруулалтанд зориулж хуримтлагдсан мөнгөн хөрөнгийг богино хугацаат хөрөнгө оруулалтууд дуусгавар болсонтой холбоотой бууралт нөлөө үзүүлснээр хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний нийт дүн -14.4 тэрбум төгрөг байна.
- Групп нь үндсэн үйл ажиллагааны тодорхой хэсгийг шугамын эзэлээр санхүүжүүлж, вагоны хөрөнгө оруулалтыг 70 хувийг эзэлээр санхүүжүүлж буйтай холбоотой олон улсын банкнаас зээл авсан зэргээс хамаарч санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнээс 15 тэрбум төгрөг орж ирсэн байна.

Импорт тээвэр

2024 онд Монложистикс Групп нь “Төв Азийн Зам” ХХК-г нэгтгэсэнээр нийт импортын борлуулалтын хэмжээ 97%-аар өссөн байна.

Орлого үр дүнгийн тайлан (сая.төг)	2022	2023	2024	Growth
Тээврийн тоо хэмжээ	111.09 мян.тн	90.32 мян.тн	91.62 мян.тн	1%
Борлуулалтын орлого	102,546	84,286	165,995	97%
Борлуулалтын өртөг	(90,980)	(76,197)	(152,704)	
Нийт ашиг	11,566	8,089	13,290	64%
Нийт ашгийн хувь	11.3%	9.6%	8.0%	
Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал	(3,738)	(4,764)	(6,919)	
Бусад орлого (зардал)	(94)	(99)	(1,349)	
Татварын өмнөх ашиг	7,734	3,226	5,023	56%
Татварын зардал	(1,110)	(400)	(578)	
Цэвэр ашиг	6,624	2,826	4,446	57%
Цэвэр ашгийн хувь	6.5%	3.4%	2.7%	

Зах зээлийн нөхцөл байдал

2024 онд Монгол Улс гадаад улсаас 11.6 тэрбум ам.долларын үнэ бүхий бараа, бүтээгдэхүүн импортлосон нь өмнөх оны мөн үеэс 25.5%-аар өссөн үзүүлэлттэй байна. Импортын ачааны бүтцийн томоохон хэсэг болох суудлын автомашины импорт 102,353 хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71.6%-аар өссөн үзүүлэлттэй байна. 2024 оны 4-р сараас эхлэн БНХАУ-ын Тяньжин боомтод ачаа бараа саатсан нь импортын тээврийн гол сорилт байсан бөгөөд тус боомтоос гарах төмөр замын вагон хангалтын хэмжээ 4-8-р саруудад өмнөх жилээс буурсан нь тус боомтод ачаа саатах гол шалтгаан болсон. Тус боомтод чингэлэг тээвэр дунджаар 70-80 хоног саатсан бөгөөд үүний үр дүнд авто замаар тээвэрлэгдэх ачааны хэмжээ нэмэгдсэн.

Үйл ажиллагааны товч мэдээлэл

Монложистикс Групп нь 2024 онд импортын тээврийн салбарт олон чухал алхмуудыг хийж, зах зээлд тэргүүлэх байр сууриа бататгасан. Үүнд: 2024 оны 6-р сард Монложистикс Групп нь ТЭСО Группийн охин компани болох “Төв Азийн Зам” ХХК-ийн 51% хувьцааг худалдан авч, хяналтын багцыг эзэмших болсон. Энэ хөрөнгө оруулалт нь суудлын автомашины импортын тээврийн зах зээлд Монложистикс Группийн байр суурийг бэхжүүлэхэд чиглэгдсэн стратегийн алхам байв. Энэхүү нэгтгэлээс импортын тээврийн нэг чухал төрөл болох автомашины тээврийн зах зээлд томоохон тоглолч болох зорилготой юм.

2024 оны үр дүн

2024 онд Монложистикс Групп нь импортын автомашины тээврийн салбарт тэргүүлэгч байр суурьтай “Төв Азийн Зам” ХХК-ыг нэгтгэсэнээр нийт борлуулалтын хэмжээ 97%-аар өссөн байна. “Төв Азийн Зам” ХХК нь зөвхөн автомашин тээвэрлэхээс гадна автомашины худалдан авалт, борлуулалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог нь тээврийн хэмжээнээс давсан борлуулалтын өсөлтөд гол нөлөө үзүүлжээ. Мөн 2024 оны 4-р сараас эхлэн Тяньжин боомтод үүссэн ачаалал, бөглөрийн улмаас тээврийн хугацаа удааширч эхэлсэнтэй холбоотойгоор төмөр замын тээврийг авто замын тээврээр орлуулах шаардлага үүссэн. Энэ өөрчлөлт нь тээвэрлэлтийн өртгийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлсэн байна.

2025 оны хүлээлт

2025 оны Монгол Улсын импортын тээврийн зах зээлд дараах гол хүлээлтүүд байна. Үүнд:

- Долларын ханш, шатахууны үнэ зэргээс тээврийн зардал шууд хамааралтай тул тээврийн үнэ өсөх магадлалтай.
- Засгийн газар болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр баригдах томоохон төслийн бүтээн байгуулалттай холбоотой ачаа тээврийн хэмжээ өсөн нэмэгдэх боломжтой.
- Төмөр зам, ачиж буулгах терминалын хувьд өнгөрсөн жилээс хойш дорвитой өөрчлөлт гараагүй тул оргил ачааллын саруудад Тяньжин боомт, Замын-Үүд, Улаанбаатар зэрэг томоохон ачаа тээврийн голлох цэгүүдэд ачаа саатах, тээвэрлэлтийн хугацаа удаашрах магадлалтай.
- Импортын автомашины дугаар олголтын хязгаарлалттай холбоотой импортын автомашины тоо буурч болзошгүй.

ОРЛОГО

165,995 сая.төгрөг

97%

ЦЭВЭР АШИГ

4,446 сая.төгрөг

57%



ОРЛОГО

26,216 сая.төгрөг

6%

ЦЭВЭР АШИГ

897 сая.төгрөг

(-8%)

Экспорт тээвэр

2024 онд Монгол Улсын экспортын хэмжээ түүхэн дээд хэмжээнд хүрч нийт 84.5 сая тонн бүтээгдэхүүн экспортод гаргасан нь өмнөх оноос 7.2%-ийн өсөлттэй байна.

Орлого үр дүнгийн тайлан
(сая.төг)

	2022	2023	2024	Growth
Тээврийн тоо хэмжээ	68.37 мян.тн	157.32 мян.тн	168.56 мян.тн	7%
Борлуулалтын орлого	7,122	24,638	26,216	6%
Борлуулалтын өртөг	(5,738)	(22,965)	(24,514)	
Нийт ашиг	1,384	1,673	1,702	2%
Нийт ашгийн хувь	19.4%	6.8%	6.5%	
Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал	(154)	(411)	(475)	
Бусад орлого (зардал)	69	(154)	(203)	
Татварын өмнөх ашиг	1,299	1,108	1,024	(8%)
Татварын зардал	(130)	(133)	(127)	
Цэвэр ашиг	1,169	976	897	(8%)
Цэвэр ашгийн хувь	16.4%	4.0%	3.4%	

Зах зээлийн нөхцөл байдал

2024 онд Монгол Улсын экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч нийт 84.5 сая тонн бүтээгдэхүүн экспортод гаргасан нь өмнөх оноос 7.2%-ийн өсөлттэй байна. Үүнд Нүүрс: 74.2 сая тонн, Төмрийн хүдэр: 5.9 сая тонн, Зэсийн баяжмал: 2.1 сая тонн, Жонш: 1.2 сая тонн, Цайр: 0.3 сая тонн түүхий эд багтаж байна. 2023 онд БНХАУ-ын коксжих нүүрсний импортын 46.2%-ийг Монгол Улс нийлүүлж байсан бол 2024 онд энэ үзүүлэлт 49.8% болж нэмэгдсэнээр манай улс тэргүүлэх нийлүүлэгч байр сууриа хадгалж байна.

УБТЗ ХНН нь 2024 онд гол замын ачааллыг бууруулах зорилгоор түрээсийн вагонуудыг буцааж эхэлсэн нь хувийн эзэмшлийн вагоны тээврийн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Үйл ажиллагааны товч мэдээлэл

Төмөр замын тээврийн гацалтыг бууруулах, хөдлөх бүрэлдэхүүний хүртээмжийг сайжруулах чиглэлээр хамтын ажиллагааны шинэ гэрээ, зохицуулалтууд хэрэгжүүлж эхэлсэн. Үүнээс гадна Монложистикс Групп IPO-ийн хүрээнд экспортын тээврийн үйл ажиллагаанд шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулалт хийж, эхний ээлжийн вагонуудаа ОХУ-аас амжилттай хүлээн авсан бөгөөд дараагийн 40 вагон удахгүй ирэх хүлээлттэй байна.

2024 оны үр дүн

Монложистикс Групп 2024 онд экспортын ачаа тээврийг 168 мянган тоннд хүргэж, өмнөх оноос 7%-ийн өсөлттэй ажиллалаа. Үүнтэй зэрэгцэн борлуулалтын орлого 6%-аар нэмэгдсэн боловч нийт ашиг 8%-аар буурсан үзүүлэлттэй байна. Экспортын салбарт голчлон төмөр замаар тээвэрлэлт хийдэг Монложистикс Групп нь 2024 онд Монгол Улсад шинээр ашиглалтад орсон Тавантолгой-Ханги боомтын чиглэлийн төмөр замаар тээвэрлэлтийг амжилттай эхлүүлсэн нь экспортын хэмжээ нэмэгдэхэд чухал хувь нэмэр орууллаа.

2025 оны хүлээлт

Монгол Улсын экспортын хэмжээг 2025 онд 83 сая тонн байх зорилт тавьсан ба үүний ихэнх хувийг нүүрс тээвэр эзэлдэг. Экспортыг нэмэгдүүлэх, нүүрсний тээвэрлэлтийг хэвийн явуулах, сайжруулах, төмөр замын тээврийн тарифыг авто замын тээвэртэй өрсөлдөхүйц болгох зорилгоор Зүүнбаян-Цогтцэций чиглэлийн төмөр замын суурь бүтцийн тарифыг 50%-аар бууруулсан нь төмөр замаар тээвэрлэгдэх нүүрс тээврийн хэмжээг нэмэгдүүлэх хөшүүрэг болохоор байна. Мөн Оюу толгойн гүний уурхайн хүчин чадал нэмэгдсэнтэй холбоотойгоор Монгол Улс зэсийн баяжмалын экспортын хэмжээ ойрын жилүүдэд эрс өсөх хандлагатай байгаа бөгөөд нийт экспортын тодорхой хувийг төмөр замаар экспортлох боломжтой. Монложистикс Групп нь өөрийн хөдлөх бүрэлдэхүүний баазыг нэмэгдүүлж, урт хугацааны нийлүүлэлтийн гэрээний тоог өсгөх замаар зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Транзит ТЭЭВЭР

2024 онд Монгол улс төмөр замын транзит тээвэр нийт 5.3 сая.тн ачааг тээвэрлэж гүйцэтгэснээс хийснээс Монложистикс групп нь 827 мян.тн буюу зах зээлийн 16%-ийг эзэлж байна.

Орлого үр дүнгийн тайлан (сая.төг)	2022	2023	2024	Growth
Тээврийн тоо хэмжээ	203.17 мян.тн	767.96 мян.тн	827.82 мян.тн	8%
Борлуулалтын орлого	21,553	87,942	95,648	9%
Борлуулалтын өртөг	(18,914)	(81,353)	(88,166)	
Нийт ашиг	2,639	6,588	7,481	14%
Нийт ашгийн хувь	12.2%	7.5%	7.8%	
Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал	(1,171)	(1,476)	(1,671)	
Бусад орлого (зардал)	470	185	(90)	
Татварын өмнөх ашиг	1,938	5,297	5,720	8%
Татварын зардал	(189)	(532)	(573)	
Цэвэр ашиг	1,749	4,765	5,147	8%
Цэвэр ашгийн хувь	8.1%	5.4%	5.4%	

Зах зээлийн нөхцөл байдал

Төмөр замын транзит тээвэрт УБТЗ ХНН гол үүрэг гүйцэтгэж, 2024 онд 5.3 сая тонн транзит ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 3.5%-аар өссөн үзүүлэлттэй байна. Монголын нутгаар дамжин өнгөрөх транзит ачаа тээвэрлэлтийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор Улаанбаатар төмөр замын

гол зам дагуух өртөө, зөрлөгийн салбар замууд дээр 4,000 гаруй вагон зогсож бөөгнөрөл үүссэн. Энэ нь голчлон Эрээн-Замын үүд өртөөний хүлээн авах хүчин чадал дээд цэгтээ хүрсэнтэй холбоотой бөгөөд өртөөний зам ихэнхдээ дүүрч, нэмэлт ачаа хүлээн авах боломжгүй болсон. Үүний улмаас Замын-Үүд боомтод транзит ачаа тээвэрлэлтийн саатал, түгжрэл үүссэн. Төлбөр тооцооны хувьд ОХУ-Украины дайнтай холбоотой барууны орнуудын тавьсан эдийн засгийн хоригийн улмаас ОХУ-ын томоохон банкууд SWIFT системээс хасагдсан. Үүний нөлөөгөөр уламжлалт банк хоорондын гүйлгээ хийхэд хүндрэл үүсч, төлбөрийн хугацаа уртассан.

Үйл ажиллагааны товч мэдээлэл

2024 онд Монгол улс нийт 5.3 сая.тн ачааг төмөр замын транзит тээврээр гүйцэтгэснээс Монложистикс Групп нь 827 мян.тн ачааг тээвэрлэсэн буюу зах зээлийн 16%-г эзэлж байна. Энэ нь өнгөрсөн жилээс 8%-аар нэмэгдсэн үзүүлэлт юм.

2024 оны үр дүн

ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээнээс шалтгаалан төлбөрийн тодорхойгүй нөхцөл байдал үргэлжилж, хориг арга хэмжээ шат дараатайгаар чангарсан нь ОХУ болон БНХАУ-ын хоорондын худалдаанд сөргөөр нөлөөлсөн хэдий ч, Монложистикс Групп транзит тээврийн чиглэлд зах зээлд эзлэх байр сууриа хадгалж, тээврийн хэмжээг 8%-аар нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд компанийн цэвэр ашиг мөн 8%-аар өсөх нөхцөл бүрдсэн байна.

2025 оны хүлээлт

- ОХУ болон БНХАУ-ын худалдааны эргэлт ойрын жилүүдэд буурах төлөвгүй байгаа ч, хоёр улс төлбөр тооцооны асуудлыг бүрэн шийдвэрлээгүй хэвээр байна. Энэ нь зарим тодорхойгүй байдлыг хадгалж, тээвэр, ложистикийн салбарт тодорхойгүй нөхцөл байдал үүсгэж байна.
- БНХАУ-ын экспортын тээврийг дэмжих бодлого буюу тээврийн subsidy (татаас) нь 2023-2024 онд Дэлхийн худалдааны байгууллагын (WTO) шүүмжлэл, гадаадын улс орнуудын эсэргүүцэл, мөн Хятадын дотоод төсвийн шахалт зэргээс шалтгаалан татаасыг бууруулж, заримыг бүрмөсөн цуцалсан. Үүнээс шалтгаалан БНХАУ-с ОХУ руу чиглэсэн ачаа тээвэрлэлтийн зардлыг нэмэгдүүлж, зарим ачаа тээврийн урсгалд саатал үүсгэх магадлалтай. Энэ нь тээвэрлэлтийн өртөг нэмэгдэж, зарим ачаа тээвэрлэгчид өөр чиглэлүүдийг сонгох, тээвэрлэлтийн хугацаа уртсах зэрэг сөрөг үр дагавартай.

орлого

95,648 сая.төгрөг

9%

ЦЭВЭР АШИГ

5,147 сая.төгрөг

8%

орлого

18,514 сая.төгрөг

3%

ЦЭВЭР АШИГ

983 сая.төгрөг

50%

Бусад тээвэр

Тяньжин боомт дахь бөөгнөрөлтэй холбоотой Замын Үүд-Улаанбаатар хоорондын тээвэр нэмэгдсэнээр нийт дотоод тээврийн хэмжээ 36.6 мян.тн буюу өнгөрсөн жилээс 37% нэмэгдсэн байна.

Орлого үр дүнгийн тайлан (сая.төг)	2022	2023	2024	Growth
Тээврийн тоо хэмжээ	13.21 мян.тн	26.73 мян.тн	36.65 мян.тн	37%
Борлуулалтын орлого	8,383	18,046	18,514	3%
Борлуулалтын өртөг	(7,408)	(16,267)	(16,596)	
Нийт ашиг	976	1,778	1,919	8%
Нийт ашгийн хувь	11.6%	9.9%	10.4%	
Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал	(474)	(719)	(784)	
Бусад орлого (зардал)	141	(261)	(405)	
Татварын өмнөх ашиг	643	798	730	(9%)
Татварын зардал	(78)	(145)	253	
Цэвэр ашиг	565	654	983	50%
Цэвэр ашгийн хувь	6.7%	3.6%	5.3%	

Зах зээлийн нөхцөл байдал

Авто тээврийн хувьд 2024 оны 5-р сараас эхлэн Тяньжин боомтод Монгол улс руу ачигдах чингэлгүүдийн бөөгнөрөл үүсч, хүлээлгийн хугацаа 70-80 хоногт хүрсэн бөгөөд үүнтэй холбоотой хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл зэрэг яаралтай барааг автомашинаар тээвэрлэх, чингэлгүүдийг төмөр замын терминалаас автомашинд шилжүүлэн ачих зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөн БНХАУ-с ОХУ руу чиглэсэн төмөр замын тээврийн саатлаас шалтгаалан авто замын тээврийн эрэлт нэмэгдсэн.

Үйл ажиллагааны товч мэдээлэл

Монложистикс Групп нь хот хоорондын автотээврийн үйл ажиллагааг өргөжүүлэх, байгаль орчинд ээлтэй байх зорилгын хүрээнд автомашины парк шинэчлэлтийг хийж, агуулахын үйлчилгээ болон чингэлэг хадгалалтын үйлчилгээг нэвтрүүлсэн.

Монложистикс групп импорт, экспорт, транзит ачаанаас гадна бусад төрлийн тээврээр 36.65 мян.тонн ачаа тээвэрлэсэн нь нийт тээвэрлэсэн ачааны 3%-г эзэлж байна.

2024 оны үр дүн

Монложистикс Группийн хэтийн стратеги болох Ази, Европыг холбосон ложистикийн төв болох зорилтын хүрээнд бид БНХАУ-ын Тяньжин хотод салбар компаниа байгуулсан. Мөн импортын тээврийн цар хүрээгээ тэлэх бодлогын хүрээнд агаарын тээвэрт чиглэсэн тусгай үйлчилгээ үзүүлэх Монложистикс Экспресс ХХК-ийн үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.

- **Гадаад тээвэр:** ОХУ нөхцөл байдалтай холбоотой гадаад улс дахь тээврийн хэмжээ 70%-аар буурсан байна.
- **Дотоод тээвэр:** Тяньжин боомтын бөөгнөрөлтэй холбоотой авто замын тээвэр нэмэгдсэнээр Замын Үүд - Улаанбаатар хоорондын тээвэр нэмэгдсэнээр нийт тээврийн хэмжээ 36.6 мян.тн буюу өнгөрсөн жилээс 37%-р нэмэгдсэн байна.

2025 оны хүлээлт

Технологийн шинэчлэл, автоматжуулалт, дижитал платформуудыг ашиглан тээвэр ложистикийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгох хүлээлт байна.

2025 ОНЫ ЗОРИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2025 оны санхүүгийн төлөвлөгөө

Хүлээлт 2025 (тэрбум.төгрөг)	2024 гүйцэтгэл	2025 төлөвлөгөө
Цэвэр ашиг	10.3	13-14
Цэвэр ашгийн хувь	3.4%	3.4%

2025 оны санхүүгийн төлөвлөгөөний суурь таамаглал

Монложистикс Групп нь 2025 оны бизнес төлөвлөгөөнд эдийн засгийн өсөлтийн 6%, ам.долларын жилийн дундаж ханшийг 3559 төгрөг, Монгол Улсын ложистикийн салбарын өсөлтийг 19% байхаар төлөвлөсөн. 2025 онд Групп нь өсөлтийг импортын тээврийн төрлийг нэмэгдүүлж, эзэмшлийн вагонуудаа экспортын тээвэрт явуулж эхэлснээр бий болгохоор төлөвлөж байна. 2025 онд Монложистикс Группийн 20 жилийн ойг тохиолдуулан зах зээлд дэвшилтэт технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн танилцуулахаар бэлдэж байна.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын дүн (сая.төгрөг)	Төлөвлөгөө	Зарцуулалт	Үлдэгдэл
1. Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062	1,502	8,062
2. Эргэлтийн хөрөнгө	2,923	2,923	2,923
3. Төв Азийн Зам ХХК		3,500	
Нийт	10,985	7,925	3,060

1. Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт

Монгол Улсын Засгийн Газраас баримталж буй экспортыг нэмэгдүүлэх, төмөр замын суурь бүтцийн сүлжээг өргөжүүлэх бодлого чиглэлийн хүрээнд 2 цуваа буюу 100 ширхэг 13-6953 загварын тавцант вагоныг ОХУ-аас худалдан авахаар төлөвлөсөн. Гэвч дотоод болон гадаад хүчин зүйлс, тухайлбал Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилт, дотоодын вагоны эрэлт хэрэгцээ мөн хөрш орны дайны нөхцөл байдал зэргээс шалтгаалан вагоны тоо ширхэг, хөрөнгө оруулалтын хугацаа болон вагоны төрөлд өөрчлөлт оруулахаар Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-өөс шийдвэрлэсэн. Үүний дагуу ОХУ-аас 50 ширхэг 12-1293 загварын ачааны хагас вагон шинээр худалдан авах гэрээ байгуулж, эхний 10 вагон 2024 оны 12 дугаар сард Монгол Улсад орж ирэн тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа бол дараагийн 40 вагон үйлдвэрээс гарч, Монгол Улс руу тээвэрлэгдэхэд бэлэн болоод байна.

Бид 50 ширхэг вагоны гэрээний төлбөрт 8 тэрбум төгрөг төлөхөөс 2024 онд 1,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулж, үйлдвэрлэгч талд шилжүүлээд байгаа бол үлдэгдэл төлбөрийг Монгол Улсад вагонууд орж ирсний дараа төлөхөөр төлөвлөж байна.

2. Эргэлтийн хөрөнгийн санхүүжүүлэлт

Охин компаниудын үйл ажиллагааг өргөжүүлэх, өсөлтийг дэмжих, стратеги төлөвлөгөөг хангахын тулд эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор 2,9 тэрбум төгрөгийг зарцуулсан.

3. Шинэ бизнес: М&А - Төв Азийн Зам ХХК

Монложистикс Групп нь тээвэр ложистикийн салбарт үйл ажиллагаа нь жигдэрсэн, зах зээл дээр хэдийн байршсан компани худалдан авах замаар бизнесийн цар хүрээ, зах зээлд эзлэх байр сууриа тэлэхээр ТЭСО Группийн охин компани болох Төв Азийн Зам ХХК-ийг худалдан авах, хөрөнгө оруулах замаар хяналтын багц буюу 51%-ийг өөртөө нэгтгэсэн. Энэхүү хөрөнгө оруулалтад 3,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцууллаа.



3

Тогтвортой хөгжил

Үйл ажиллагааны тайлан 2024



НИЙГЭМ БА БАЙГАЛЬ ОРЧИН

Монложистикс Групп нь тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд гадаад болон дотоод бүхий л оролцогч талуудын урт хугацааны үнэ цэн, тогтвортой өсөлтийг бий болгоход чиглэсэн, компанийн засаглалыг сайжруулах, байгаль орчинд ээлтэй байх олон ажлуудыг 2024 онд шинээр эхлүүлсэн болон өмнөх онуудад эхлүүлсэн төсөл хөтөлбөрүүдээ амжилттай үргэлжлүүлэн ажиллалаа.

Бид тогтвортой хөгжлийн төлөө үйл ажиллагаандаа ISO олон улсын стандартыг бүрэн хэрэгжүүлж эхэллээ. ISO стандарт нь тогтвортой хөгжлийн зорилго тус бүртэй хэрхэн нийцэж байгааг тоон хэлбэрээр зурагт харуулав.



ШАМБАЛА 2056

Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд хуурай газрын экосистемийг урт хугацаанд хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг урлаг, технологи ашиглан бууруулах зорилготой “Шамбала-2056” төсөлтэй бид хамтран ажилладаг. Дорноговь аймгийн Эрдэнэ сум, Төхөмийн хөндий, Ар цацын ус буюу нэн цөлжилттэй газар нутагт 2016 оноос 2056 он хүртэл 40 жилийн хугацаанд хэрэгжих уг төслийн үр дүнд хайлаас мод бүхий ногоон зурвас үүсээд байна.

2024 оноос эхлэн “Шамбала-2056” төслийн талбай дахь модны хяналтыг NASA MODIS хиймэл дагуулын системээр дамжуулан хийж, тооцоолол болон хөндлөнгийн аудитын үйл ажиллагааг MARTENSITE ANALYTICA компани гүйцэтгэж байна.

Монложистикс Групп нь энэхүү төслийг дэмжин хамтран ажилласнаар дараах үр нөлөөг байгаль, экологид бодитоор үзүүлж, холбогдох батламжийг гардан авсан. Үүнд:



+ Нүүрстөрөгчийн хуримтлал
t[C] - 186.688 t[C] +/-29.496

+ Биомассын ялгарал
t) - 397.209 t[C] +/-62.759



ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР

Монложистикс Групп нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн бага нөлөөлөлтэй төмөр замын тээврээр уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд анхаарч ажиллаж байна.

Монложистикс Группийн хэмжээнд 2024 онд нийт 1.125 мянган тонн ачаа тээвэрлэснээс 95 хувь буюу 1.070 мянган тонн ачааг төмөр замаар тээвэрлэсэн байна. Монложистикс Групп байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн багатай тээврийн төрөл болох төмөр замын тээвэрт илүү анхаарч өөрийн эзэмшлийн вагон худалдан авсан нь уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, эрүүл мэндийг дэмжих, инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг тогтвортой хөгжлийн олон зорилгуудад нийцсэн үйл ажиллагаа явуулж байгааг илтгэж байна.

Бид байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах, шатахуун зарцуулалтыг оновчтой болгох, агаар болон дуу чимээний бохирдлыг багасгах зорилгоор тээврийн хэрэгслийн автопаркаа үе шаттай шинэчлэн сайжруулж байна. 2024 онд Монложистикс Тракинг ХХК нь олон жил ашиглагдсан, өндөр шатахуун зарцуулалттай, хорт утаа ихээр ялгаруулдаг 6 ширхэг хүнд даацын ачааны автомашинаа бүрэн шинэчилж, түлшний зарцуулалт багатай, байгаль орчинд ээлтэй технологитой цоо шинэ автомашинаар сольж, парк шинэчлэлт хийлээ.



ЭНЭХҮҮ ШИНЭЧЛЭЛ НЬ ДАРААХ ҮР ӨГӨӨЖИЙГ БИЙ БОЛГОЖ БАЙНА.

❑ Нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулав.

Шинэ автомашинууд нь шатахуун зарцуулалтын хувьд өмнөх загваруудаас 15-30 хувиар бага түлш хэрэглэж, улмаар CO₂ зэрэг хорт хий ялгаруулах хэмжээг мэдэгдэхүйц бууруулж байна.

❑ Агаарын бохирдлыг багасгав.

Евро-5 болон Евро-6 стандартын хөдөлгүүртэй эдгээр автомашинууд нь азотын ислүүд (NOx), нарийн ширхэгт тоосонцор (PM2.5, PM10) зэрэг бохирдуулагч бодисын ялгарлыг өмнөх загваруудаас 40-60 хувиар бууруулсан.

❑ Шуугиан ба дуу чимээний бохирдлыг бууруулав.

Шинэ технологийн ачаар хөдөлгүүрийн дуу чимээ, замын чимээ шуугиан багассан нь хот суурин газрын дуу чимээний бохирдолд эергээр нөлөөлж байна.

❑ Түлшний хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлэв.

Шинэ автомашинуудын түлш зарцуулалт багассан тул хорт утаа ялгаруулалт буурахын зэрэгцээ компанийн үйл ажиллагааны зардлыг хэмнэх давхар ач холбогдолтой.

Автопаркийн шинэчлэл нь зөвхөн манай компанийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлээд зогсохгүй, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн төлөвлөгөөт ажил юм. Цаашид ч бид хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, эко тээвэрлэлтийг дэмжих бодлогыг тууштай хэрэгжүүлэх болно.





DO GOOD HUB 2024



Залуучуудын оролцоог дэмжих, дуу хоолойг нийгэмд хүргэх, залуучуудын сайн дурын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилготой “Do Good Hub” төв нь 2023 оны 09-р сараас хойш үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна. “Лантуун дохио” ТББ-ын Үүсгэн байгуулагч Ч.Ганжавхлантай хамтран эхлүүлсэн уг төвийн үйл ажиллагааг Монложистикс Групп 3 дах жилдээ тасралтгүй дэмжин, санхүүжүүлэн ажиллаж байна. “Do Good Hub” төвтэй хамтран ажиллаж буй зарим байгууллагууд, тэдний 2024 онд хийсэн ажлыг товч танилцуулбал:



BREATHE MONGOLIA CLEAN AIR COALITION

Тус ТББ нь цэвэр агаар, уур амьсгалын өөрчлөлт болон эрүүл мэнд гурвын огтлолцол дээр ажилладаг ашгийн бус байгууллага юм.

➤ Агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлын уялдаа холбоог таниулах, чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж 610 гаруй сурагчид, 21 сэтгүүлчдийг хамруулсан. Агаарын бохирдлыг бууруулах бодлогод хяналт тавих, санхүүжилтийг ил тод болгох зорилгоор цахим өргөдлийг боловсруулж, нийт 71,400 иргэний гарын үсгийг цуглуулснаар УИХ-аас Ерөнхий хяналтын сонгол хийх нөхцөлийг бүрдүүлж, уг сонголд иргэний нийгмийн зүгээс хараат бусаар, хяналт хийн ажилласан.



МОНГОЛ ТУУРГАТАН ХЭЛ ХУУРЫН НИЙГЭМЛЭГ

Нүүдэлчдийн эртний язгуур өвөг хөгжим ахуй соёлын хэмнэл болсон аман хэл хуур хөгжмийн талаарх мэдлэг ойлголт мэдээллийг олон нийтэд хүргэх, түгээх, дэлгэрүүлэх зорилготой.

➤ Тайвань улсад болсон Дэлхийн хэл хуурын фестивальд оролцох, “НҮҮДЭЛЧДИЙН ХЭМНЭЛ – ХЭЛ ХУУРЫН ТАТЛАГА” аман хэл хуур тоглогчдын анхдугаар наадам, соёлын өв хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах зэргээр өргөн цар хүрээтэй үйл ажиллагааг 2024 онд зохион байгуулж ажилласан.





МӨРӨӨДӨЛ ЗУСЛАН

Хүүхдийг амьдрах ухааны чадварт суралцуулах зорилгоор хувь хүний хөгжил, танин мэдэхүй, байгаль орчин, урлаг, спортын олон төрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

- 2024 онд нийт 5500 гаруй хүүхдийг зусланд хамруулж эрүүл орчинд өөрийгөө хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажилласан.



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЖИГҮҮР

Хүүхдийн сэтгэл зүйн чадварыг тоглоомоор дамжуулан хөгжүүлэх зорилготой.

- 2024 онд үйл ажиллагаагаа тэлж, шатраас гадна англи хэл, гоо даамны сургалтыг мэргэжлийн багш нартай хамтран зохион байгуулдаг болсон.



ГУРВАН ТУЛГУУРТ ХӨГЖЛИЙН ГҮҮР ТББ

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох, УБ хотын утааг бууруулах, хот байгуулалтын хөгжлийн төлөвлөлтийг бодитоор хэрэгжүүлэх зорилготой.

- 2024 онд үйл ажиллагаагаа тэлж, шатраас гадна англи хэл, гоо даамны сургалтыг мэргэжлийн багш нартай хамтран зохион байгуулдаг болсон.



ЦЭЦЭЭ ГҮН РОТАРАКТ КЛУБ

Боловсрол болон эрүүл мэндийн чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг.

- Тус клуб нь 53 идэвхтэй гишүүн, 180 орчим төгсөгчтэй бөгөөд суурь боловсрол, бичиг үсэг, өвчлөлтөөс сэргийлэх, эмчилгээ үзүүлэх, эх хүүхдийн эрүүл мэнд, байгаль эх дэлхийгээ хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, менторшип, тэтгэлэгт хөтөлбөрт хүүхэд залуусыг хамруулж ажиллаж байна.




ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО


Монложистикс Групп нь Монгол Улсын тээврийн салбарын гол хөдөлгөх хүч болсон хүний нөөцийг бүрдүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр тасралтгүй ажиллаж, ажилтан төвтэй хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэн 11 компанийн 240 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийт ажилтнуудын тоо: **240**


Хүйсийн харьцаа:



Насны ангилал:



Ажилласан жил:



1. Өндөр чадвартай мэргэжлийн хамт олон

Монложистикс Группийн ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах хүсэл эрмэлзэлтэйгээр өсч хөгжихөд нь компани туслах замаар өндөр чадвартай мэргэжлийн хамт олонг бүрдүүлэх хүний нөөцийн стратегийн хүрээнд 2024 онд сургалт хөгжлийн бодлого, төлөвлөгөөний дагуу олон ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

Монложистикс Групп нь Odoo ERP системийн E-Learning модулиар дамжуулан “Шинэ ажилтны чиглүүлэх сургалт”, “Ерөнхий ур чадварын сургалт”, “Мэргэжлийн сургалт зөвлөгөө, гарын авлага” зэрэг сургалт, мэдээллийг бүх ажилтнууд хаанаас ч, хэзээ ч үзэж судлах, суралцах боломжийг бүрдүүлсэн. Бид Группийн сургалт хөгжлийн үйл явц, үр дүнгийн талаар ажилтнууд болон удирдлагын багт мэдээлэл, тайланг цаг тухайд нь хүргэх зорилгоор 2024 оны 6-р сараас эхлэн Дотоод сургалтын dashboard-ыг хөтөлж эхэлсэн бөгөөд 2024 онд нийт 1220 цагийн дотоод сургалтуудад ажилтнууд хамрагдсан байна.

Удирдах ажилтнуудыг гаднын нэр хүндтэй сургалтын хөтөлбөр, арга хэмжээнүүдэд хамруулах, туршлага солилцон, мэдлэг хуримтлуулах боломж олгох, цаг үетэйгээ хөл нийлэн, дэлхийн хөгжлөөс хоцролгүй суралцах, өөрийгөө чадавхжуулахад нь туслах зорилгоор Монложистикс Группийн зарим гүйцэтгэх захирлуудыг АНУ-ын бизнесийн шилдэг их сургуулиудын нэг болох Стэнфордын Их Сургуульд “Дижитал өөрчлөлтийн хөтөлбөр”-т амжилттай хамруулсан бол Хүний нөөцийн багаа Азийн хамгийн том хүний нөөцийн форум болох Сингапур улсад зохион байгуулагдсан People Matters TechHR олон улсын арга хэмжээнд оролцууллаа.



2023 оноос эхлэн СЭЗИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн Магистрын хөтөлбөрт өсөх ирээдүйтэй ажилтнуудыг хамруулж эхэлсэн бөгөөд 2024 онд 8 ажилтан компанийн тэтгэлэгтэйгээр магистрын хөтөлбөрт амжилттай суралцаж байна. Тус сургуулийн “Манлайлал” 2 кредиттэй хичээлийг Сингапурын Үндэсний Их Сургуулийн төгсөгч, Группийн дотоод сургагч багш нар удирдан явуулж, ирээдүйн манлайлагч мэргэжилтнүүдийг бэлдэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулсаар байна.



Группийн залуу мэргэжилтнүүдийг AXIOM сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулсан “Манлайлал” сэдэвт интерактив сургалтад мөн хамруулсан бол ажилтны хувийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу зөөлөн ур чадварын 864 хүн/цагийн сургалтууд, англи хэлний 728 хүн/цагийн сургалтуудад ажилтнуудыг жилийн турш хамрууллаа.

Монложистикс Групп нь жилд дунджаар 120 гаруй сая төгрөгийг сургалт хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулж ажилтан бүрийг сурч хөгжих боломжоор ханган, ур чадварыг нь нэмэгдүүлэх замаар өндөр чадвартай, мэргэжлийн хамт олныг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч ажиллаж байна.

Тийм ч учраас Монголын хамгийн том ажлын байрны платформууд болох Zangia.mn, NitoPay болон Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам хамтран зохион байгуулсан “MONGOLIAN LABOR MARKET SUMMIT-2024” арга хэмжээнд Монложистикс Групп 3 дахь жилдээ амжилттай оролцож, “Best training – Сургалт хөгжлийг дэмжигч шилдэг ажил олгогч”, “Best culture – Шилдэг соёл бүхий ажил олгогч” 2 номинацид нийт 200 гаруй байгууллага өрсөлдсөнөөс шилдэг 3 байгууллагад нэр дэвшиж, амжилтаа бататгалаа.

2. Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

“Future ceo 2” хөтөлбөр

Монложистикс Групп нь хүний нөөцийн бодлогын хүрээнд “Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл” үнэт зүйлсээ баримтлан, оюутан залуусын ирээдүйн хөгжилд оюунлаг хөрөнгө оруулалт хийхээр “FUTURE CEO 2” тэтгэлгийг 2 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэ цэн бүтээх, ирээдүйн манлайлагчдыг төрүүлэхэд бодит дэмжлэг болж, оюутан залуусын академик амжилтыг карьер амжилт болгон дэмжих зорилготой энэхүү тэтгэлэгт ирээдүйд олон улсын зах зээлд ажиллах гадаад хэлтэй, олон улсын харилцааны мэргэжлээр 3, 4-р курст суралцаж буй оюутнуудыг хамрууллаа. Шалгарсан оюутнуудад сургалтын 100% тэтгэлэг олгохоос гадна, 3-р курсээсээ эхлэн Монложистикс Группэд цалинтай ажиллах боломжийг олгодог.

Түүнчлэн “FUTURE CEO 2” тэтгэлгийн эзэд болж буй 4 оюутнуудын хувьд Гүйцэтгэх захирлын ментор хөтөлбөр, ерөнхий ур чадварын сургалт, цалинтай ажлын байр гээд тус бүр нийт 80 сая төгрөгийн тэтгэлэг хүртэж байгаагаараа онцлогтой.



Employee day 2024

Монложистикс Группийн алсын хараа, бизнесийн стратегийг амжилттай хэрэгжүүлэх хүчирхэг багийг бий болгох, ажил олгогчийн брэндингийг ажилтан нэг бүрд хоногшуулах, ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, бүтээмжтэй, тогтвортой ажиллахад нь зэрэг нөлөөлөл үзүүлэх зэрэг олон зорилгыг агуулдаг “EMPLOYEE DAY” арга хэмжээ 4 дэх удаагаа амжилттай зохион байгуулагдлаа.

Уг арга хэмжээгээр бид Группийн нийт ажилтнуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, дотоод хяналтын тогтолцооны талаарх мэдлэгийг бататгах зорилгоор “Хөрөнгө оруулалт, хувьцаа, цалин хангамж”, “Гурван шугамын загвар” сэдвүүдээр хамгийн сүүлийн үеийн сургалт мэдээллийг өгч, Монос хүнс компанитай хамтран ажилтнуудын эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх олон талт үзлэг шинжилгээ хийгдэж, зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн ажилтан тус бүрт 300,000 төгрөг олгож, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нарийвчилсан үзлэг шинжилгээнд хамрагдах, витаминжуулалтад уриалан, идэвхжүүлж ажиллалаа.



Менежмент форум

Монложистикс Группийн удирдлагын залгамж халааг хөгжүүлэн бэлдэх зорилгоор 3 дахь жилдээ Менежмент форум арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. 2024 оны Менежмент форумд Монголын тэргүүлэх компаниудад гүйцэтгэх удирдлагаар, мэргэжлийн холбоод, ТББ-ын удирдах зөвлөлд удирдах албан тушаалд ажилласан туршлагатай Менежментийн зөвлөх П.Батхишиг захиралуригдаж, “СЕО & Стратеги” сэдвээр сургалт явуулж, хэлэлцүүлэг өрнүүллээ. Мөн 2024 оны 5-р сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан үйл ажиллагаанд форумын оролцогчид багаар ажиллан, стратеги төлөвлөгөө боловсруулах даалгавар гүйцэтгэж, илтгэл тавихаас гадна Дэйл Карнеги Трейнинг Монгол төвийн олон улсын эрхтэй сургагч багш А.Даваасүрэн бизнес хэлэлцүүлэг, сургалтыг удирдаж, оролцогчдын мэдлэг чадварыг сорьсон юм.



MLG Hiking club

Монложистикс Группийн “Инновацлаг багийн сэтгэлгээ” үнэт зүйлсийн хүрээнд сонирхол, хоббигоороо нэгдсэн залуусын санал санаачлагаар “MLG Hiking Club” байгуулагдсан юм. Уг клуб нь нийт ажилтнуудын бие болон сэтгэлзүйн эрүүл мэндийн төлөө хамт олноо уриалан 2024 онд нийт 11 чиглэлд 650км замыг 321 цаг туулсан алхалт авиралтыг амжилттай аюулгүй зохион байгуулсан юм. Энэхүү амжилтыг нь үнэлж, клубын 2024 оны идэвхитэй 5 гишүүнийг 2025 онд Монгол Улсын Гавъяат уулчин Б.Гангаамаатай хамт Монгол улсын хамгийн өндөр цэг болох Хүйтэн оргилд /4374м/ авирах 20 сая төгрөгийн үнэ бүхий аялалын эрхээр шагнаж урамшууллаа.



ESOP ХУРИМТЛАЛЫН ХӨТӨЛБӨР


Ажилтан болон ажил олгогчийн хамтран бий болгох тогтмол хуримтлалыг тэдний шууд оролцоо, хяналтын дор мэргэжлийн хөрөнгө оруулалтын компани удирдан өсгөж, үр өгөөж бий болгосноор ажилтны ирээдүйн санхүүгийн баталгааг сайжруулах хуримтлалын хөтөлбөр хэрэгжээд 3 жил болж байна.

Хөтөлбөрийн зорилго:

- Ажилтнаа урамшуулах, тэдгээрийн санхүүгийн чадварыг нэмэгдүүлэх, ирээдүйн санхүүгийн баталгааг хангах
- Үр ашигтай, олон улсын жишигт нийцсэн, хуулийн хүрээн дэх ажилтны хамтарсан хуримтлалын санг бий болгох
- Ажилтан болон ажил олгогчийн хамтын зорилгыг бий болгох
- Тогтвортой хүний нөөцийг цогцлоох

KESO ХӨТӨЛБӨР

Key Employee Stock Option (KESO) хөтөлбөр нь Монложистикс Группийн түлхүүр ажилтнуудад компанийн хувьцааг эзэмших эрх олгосноор ажилтны санхүүгийн чадавхийг сайжруулах, ирээдүйн амьдралын баталгааг бий болгох, хүний нөөцийн тогтвортой байдлыг дэмжих зэрэг ач холбогдол өндөртэй, олон улсад ашигладаг урамшууллын нэг хэлбэр юм. Группийн албан тушаалын 5-р зэрэглэлээс дээшхи ажилтнууд 2024 оны 5-р сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Менежмент форумын үеэр “Колл опционы гэрээ”-д гарын үсэг зурж баталгаажуулсан бөгөөд уг гэрээний дагуу ажилтан 3 жилийн дараа компанийн хувьцааг хөнгөлөлттэй үнээр худалдан авах эрхтэй болох юм. Монложистикс Группийн алсын хараа, эрхэм зорилгын төлөө өндөр бүтээмжтэй, тогтвортой ажиллаж, компанийн зах зээлийн үнэлгээг хамтдаа өсгөх замаар ирээдүйд харилцан ашигтай байх уг хөтөлбөр цаашид улам өргөжих болно.





ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

Үйл ажиллагааны тайлан 2024



4

Засаглал


Үйл ажиллагааны тайлан 2024

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Хувьцаа эзэмшигчдийн тоо:



Хувьцаа эзэмшигчдийн бүтэц:



ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

I. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Монложистикс Холдинг ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд удирдлага юм.

Монложистикс Холдинг ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурлыг 2024 оны 4-р сарын 27-ны өдөр зайнаас буюу цахим хэлбэрээр зохион байгуулж, шууд дамжуулалтыг хурлын платформоор болон фэйсбүүк дэх Monlogistics Group пэйж хуудсаар олон нийтэд шууд дамжуулан хүргэсэн. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц 85.57%-иар бүрдэж, хүчин төгөлдөр явагдсан. Хуралд:

1. Гүйцэтгэх захирал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г.Хишигбат компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлахын өмнө компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг товч танилцуулж;
2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э.Оюунбилэг компанийн ТУЗ-ийн цалингийн төсвийг хэлэлцэж батлахын өмнө компанийн ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж;
3. Хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н. Эрдэнэцог компанийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг тус тус танилцуулж, хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултанд хариулж оролцсон.

Хурлаас гарсан шийдвэр:

1. Монложистикс Холдинг ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батласан.
2. Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны төсвийг батласан.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**Лувсанжамба
ГАНЗОРИГТ**

Үүсгэн байгуулагч
ба ТУЗ-ийн дарга

Санхүү, олон улсын худалдааны чиглэлээр 31 жилийн туршлагатай.



**Бааст
ТЭЛЭНГЭД**

Үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн ердийн гишүүн

Тээвэр ложистикийн салбарт 31 жилийн туршлагатай.



**Өлзийбаяр
ГАНЗОРИГ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Банк, санхүү, даатгалын салбарт 23 жилийн засаглал, гүйцэтгэх удирдлагын туршлагатай.



**Ганзоригт
ХИШИГБАТ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Санхүү, хөрөнгө оруулалтаар 11 жил, засаглал удирдлагын чиглэлээр 8 жилийн туршлагатай.



**Балдан
ЭНХТҮВШИН**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Банк, санхүү, даатгалын салбарт 21 жилийн засаглал, гүйцэтгэх удирдлагын туршлагатай.



**Эрэндоо
ОЮУНБИЛЭГ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Банк санхүүгийн салбарт 31 жилийн компанийн засаглалын мэргэшсэн туршлагатай.



**Санжаа
САЙНБАТ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Худалдаа үйлчилгээний салбарт засаглал удирдлагын чиглэлээр 21 жилийн туршлагатай.



**Готов
ЦЭРЭНПҮРЭВ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Олон улсын банк санхүүгийн салбарт 41 жилийн удирдах чиглэлийн туршлагатай.



**Сэнгээ
ЭНХ-АМГАЛАН**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Бизнесийн удирдлага, засаглал, гүйцэтгэх удирдлагын 23 жилийн туршлагатай.



Цогт ДУЛАМСҮРЭН

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга бөгөөд Нийцэл хариуцсан ажилтан

Хүний нөөц, захиргаа, эрх зүй, засаглалын 21 жилийн туршлагатай.

II. Төлөөлөн удирдах зөвлөл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл юм. Хурдацтай өөрчлөгдөж буй бизнесийн талбарт үүсч болох эрсдэл ба боломжийг амжилттай удирдах чадвартай, салбар салбартаа мэргэшсэн, туршлагатай гишүүдээс Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл бүрддэг бөгөөд ердийн 5, хараат бус 4, нийт 9 гишүүнтэй.

III. ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

ТУЗ-ийн хурал

Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ нь 2024 онд ээлжит болон ээлжит бус нийт 7 удаагийн хурал зохион байгуулж, гишүүд идэвх санаачлагатай оролцсон бөгөөд хурлын дундаж ирц 96,7%. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ТУЗ-ийн хурал болон ТУЗ-ийн гишүүдээс эчнээ санал хураалт явуулах замаар 2024 онд ТУЗ-өөс нийт 60 тогтоол шийдвэрийг баталсан.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурал

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2024 онд биечлэн болон цахим хэлбэрээр хуралдаж, хороодын ажлын чиг үүргийн дагуу идэвх санаачлагатай ажилласан.



ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос тодорхойлон санал боловсруулж, 2024 оны 4-р сард хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

Батлагдсан төсвийн хүрээнд ТУЗ-ийн гишүүдэд үндсэн цалин болон хорооны даргын нэмэгдэл, хорооны гишүүний нэмэгдлийг тус тус тогтмол дүнгээр тооцон, дараах нийт цалинг ТУЗ-ийн гишүүдэд олгосон.

№	Зардлын задаргаа	Нийт зардал
1	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал	182,400,000 ₮
2	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	22,800,000 ₮
НИЙТ ЗАРДЛЫН ТӨСӨВ		205,200,000 ₮

Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үндсэн цалин болон жилийн эцсийн ашигт ажиллагаа, стратегийн гүйцэтгэлээс хамаарсан урамшуулалт цалингаас бүрдэнэ. Тайлант онд гүйцэтгэх захирлын үндсэн цалинг нэмэгдүүлсэн бөгөөд урамшуулал олгох шалгуур үзүүлэлт өөрчлөгдөөгүй.

ТУЗ-ийн сургалт хөгжил

ТУЗ-ийн гишүүдийн сургалтын хөтөлбөрийн дагуу “Дижитал шилжилт” болон “Тээвэр ложистикийн салбарын өнөөгийн байдал” сэдвээр 2 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

ТУЗ-ийн үнэлгээ

Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ, түүний гишүүд болон Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, Дотоод аудиторын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх замаар ТУЗ-ийн гишүүдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх, манлайлах, ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулан компанийн сайн засаглалыг бэхжүүлэх зорилгоор ТУЗ-ийн гүйцэтгэлийг үнэлэх журмыг 2024 онд шинээр баталсан.

ТУЗ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ нь дараах үнэлгээнүүдээс бүрдэх бөгөөд үнэлгээний асуулгуудыг компанийн засаглалын олон улсын сайн туршлага, кодексийн зарчим дээр үндэслэн боловсруулсан.

ТУЗ-ийн гүйцэтгэлийн үнэлгээний үзүүлэлтүүд




НДБЦУХороо нь ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2024 оны ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэлтийг ТУЗ-ийн 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хуралд танилцуулж, хэлэлцүүлсэн. ТУЗ-ийн 2024 оны ажлын гүйцэтгэлийн нэгдсэн тайланг дараах хүснэгтэд харуулав.

№	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖҮҮР	ҮНЭЛГЭЭ	ТАЙЛБАР
1	КЗК-д заасан шалгууруудыг хангаж байгаа эсэх	90% ба түүнээс дээш буюу Засаглал хэвийн/эрсдэлгүй түвшинд байх	97.2%	СЗХ-ний КЗК-ийн үнэлгээний тайлан
2	ТУЗ-ийн хурлын ирц нь хангалттай түвшинд байгаа эсэх	ТУЗ-ийн хурлын ирц 80% ба түүнээс дээш хувийн ирцтэй байх	96.7%	ТУЗ-ийн 7 удаагийн хурлын дундаж ирцийн үзүүлэлт
3	ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл хангалттай түвшинд байгаа эсэх	ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл 80% ба түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй эсэх	85.2%	ТУЗ-ийн 2024 оны ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл
4	ТУЗ-ийн дэргэдэх хороодын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл хангалттай түвшинд байгаа эсэх	ТУЗ-ийн дэргэдэх хороодын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл 80% ба түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй эсэх	80%	ТУЗ-ийн дэргэдэх хороодын 2024 оны ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл

IV. Компанийн засаглалын зарчмуудын хэрэгжилт, өөрийн үнэлгээ, хянан баталгаажилт

Компанийн засаглалын зарчмуудыг зөв зохистой хэрэгжүүлэх нь засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, итгэлцлийг бий болгох, компанийг эрсдэлээс хамгаалж, тогтвортой үнэ цэнийг бүтээх чухал ач холбогдогдолтой. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж болон үнэлгээний аргачлал”-ын дагуу Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-өөс Монложистикс Холдинг ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг 2024 онд анх удаа үнэлсэн. Монложистикс Холдинг ХК нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа нийт компаниудиаас “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн 97,2%-ийн үнэлгээтэйгээр, эзлүүлсэн байр буюу засаглалын зэрэглэлээр 2024 онд 2-р байрт, Компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч ТОП 20 компанийн нэгээр шалгарсан.

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ болон зах зээлийн үнэлгээний харилцан хамаарал (10.0-100.0 тэрбум төгрөг хүртэл)




Ил тод байдал, тайлагнал

Монложистикс Групп нь үйл ажиллагаандаа бизнесийн ёс зүйн хэм хэмжээг чандлан мөрдөж, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, олон нийтэд компанийн үйл ажиллагааны талаарх болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг нээлттэй, ил тод байлгаж, үнэн зөв, бүрэн гүйцэт, түргэн шуурхай тогтмол мэдээлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.

Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам” болон Монложистикс Холдинг ХК-ийн “Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ын хэрэгжилтийг хангаж, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад болон бусад оролцогч талуудад мэдээллийг нэг сувгаар хүргэх зорилгоор <https://investor.ml-holding.mn/> цахим хуудсыг 2024 онд шинээр ашиглалтанд оруулсан. 2024 онд уг цахим хуудсанд болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд дараах мэдээллүүдийг байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээллэсэн байна.

Нийтэд мэдээллэсэн тоо



НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

“Монложистикс Холдинг” ХК-ийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдуулан хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын компанид оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулах, ногдол ашгийг зохистой түвшинд хуваарилах зарчмыг баримтлан, нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээ, нөхцөлийг тухайн санхүүгийн жилийн татвар төлсний дараах цэвэр ашгийн хэмжээ, компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ-өөс тогтоохоор “Ногдол ашгийн бодлого”-д тодорхойлсон.

2023 оны ногдол ашгийн мэдээлэл

2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 3,000,609,870.76 /гурван тэрбум зургаан зуун есөн мянга найман зуун далан төгрөг далан зургаан мөнгө/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилсан билээ. Ногдол ашгийг 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр “ҮЦТХТ” ХХК-аар дамжуулан олгож, ногдол ашиг хуваарилалтын тайланг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлсэн.

2024 оны ногдол ашгийн мэдээлэл

“Монложистикс Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн №25/ТУЗ/09 тоот тогтоолоор компанийн 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 21.9% /хорин нэг аравны ес/ хувь буюу 2,137,637,638.80 /хоёр тэрбум нэг зуун гучин долоон сая зургаан зуун гучин долоон мянга зургаан зуун гучин найман төгрөг наян мөнгө/ төгрөгийг Компанийн нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн. Нэгж хувьцаа тус бүрд 5.40 /таван төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн ногдол ашиг хуваарилна. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоон, ногдол ашгийг 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр “ҮЦТХТ” ХХК-аар дамжуулан олгоно.



ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Г. Хишигбат

Монложистикс Холдинг
ХК Гүйцэтгэх захирал

Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр 11 жил, засаглал гүйцэтгэх удирдлагын чиглэлээр 8 жилийн туршлагатай.



А. Одгэрэл

Ложистик эрхэлсэн
захирал

Тээвэр ложистикийн салбарт 19 жил, засаглал, гүйцэтгэх удирдлагын чиглэлээр 8



З. Шинэ-Од

Санхүү эрхэлсэн
захирал

Худалдаа, үйлдвэрлэл, тээврийн салбарт санхүү менежмент чиглэлээр 13 жилийн ажлын туршлагатай.



Б. Азжаргал

Үйл ажиллагаа
эрхэлсэн захирал

Олон улсын худалдаа, Хүний нөөц, засаглалын 14 жилийн ажлын туршлагатай.



Т. Батзаяа

Технологи эрхэлсэн
захирал

Мэдээлэл технологийн салбарт 18 жилийн технологи, гүйцэтгэх удирдлагын туршлагатай.



Б. Ууганхүү

Стратеги, бизнес хөгжил
эрхэлсэн захирал

Дэд бүтэц, үйл ажиллагааны менежментийн чиглэлээр 8 жил, засаглалын чиглэлээр 11 жилийн туршлагатай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Толгой компанийн бизнесийн үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдан чиглүүлдэг ба Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад Санхүү, Мэдээлэл технологи, Стратеги бизнес хөгжил, Захиргаа хүний нөөц, Ложистик гэсэн 5 хэлтэс харьяалагддаг.

ОХИН КОМПАНИУДЫН УДИРДЛАГА



И.Цогбаяр

Гүйцэтгэх захирал
Монложистикс Ворлдвайд
ХХК, Монложистикс
Экспресс ХХК

Тээвэр ложистикийн салбарт 5
жилийн туршлагатай.



Б. Тэлэнгэд

Гүйцэтгэх захирал
Монложистикс Транзит ХХК

Тээвэр ложистикийн салбарт 31
жилийн туршлагатай.



А. Одгэрэл

Гүйцэтгэх захирал
Монложистикс Тракинг ХХК

Тээвэр ложистикийн салбарт
18 жил, засаглал, гүйцэтгэх
удирдлагын чиглэлээр 8
жилийн туршлагатай.



Б.Мөнхжаргал

Гүйцэтгэх захирал
Төв Азийн Зам ХХК

Гадаад худалдаа, барилга,
хөрөнгө оруулалтын чиглэлээр
11 жилийн туршлагатай.



Н.Эрдэнэбилэг

Гүйцэтгэх захирал
Каус Аустралис ХХК

Төмөр зам, тээвэр ложистикийн
салбарт 31 жилийн туршлагатай.



Тугаринов.В.А

Гүйцэтгэх захирал
Монложистикс Транс Сервис
ХХК

Төмөр зам, тээвэр ложистикийн
салбарт 15 жилийн туршлагатай.



Ч.Золбоо

Гүйцэтгэх захирал
Монложистикс Карго ХХК


Тээвэр ложистикийн салбарт 5
жилийн туршлагатай.



Гуо Хонглиан

Гүйцэтгэх захирал
Тяньжин РТ Ложистикс ХХК

БНХАУ-ын төмөр зам, далайн
тээврийн салбарт 30 жилийн
туршлагатай.



ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

MSE: **MLG**
 Гаргасан нийт хувьцаа: **395,858,822 ширхэг**
 2024 оны эцсийн хаалтын ханш: **195 төгрөг**
 Зах зээлийн үнэлгээ: **77.2 тэрбум төгрөг**

Тайлант хугацаанд компанийн 23,755,044 ширхэг үнэт цаас нийт 4,824,743,962 төгрөг буюу өдөрт дунджаар 96,565.22 ширхэг хувьцаа 19,612,780.33 төгрөгөөр арилжаалагджээ.

Монложистикс Холдинг ХК нь 2024 оны 1-р сарын 16-ны өдрөөс Монголын хөрөнгийн бирж ХК-ийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам”-ийн дагуу ТОП-20 индексийн багцад орсон билээ.

Хувьцааны ханш:

- Дундаж: 177.74 төгрөг
- Хамгийн өндөр: 204.79 төгрөг (2024.01.04-ний өдөр)
- Хамгийн бага: 160.5 төгрөг (2024.06.17-ны өдөр)

ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ МЭДЭЭЛЭЛ

Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 02-р сарын 07-ны өдрийн 25/ТУЗ/10 тоот тогтоолын дагуу олон нийтэд санал болгож гаргасан хувьцааныхаа хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тодорхой хэсгийг дараах нөхцөлөөр эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэлээ.

Эргүүлэн худалдаж авах хувьцааны нийт тоо, ширхэг	4,800,000 ширхэгээс ихгүй
Эргүүлэн худалдан авах захиалгын дээд үнэ	210 төгрөг/хувьцаа
Эргүүлэн худалдан авах үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа	2025.04.01- 2025.12.31-ний өдрийг дуустал
Эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийн дүнгийн дээд хэмжээ	1,008,000,000 төгрөг

Хаалтын ханш



Арилжаалагдсан хувьцааны тоо

ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

Үйл ажиллагааны тайлан 2024

ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ СТРАТЕГИ

Монложистикс Холдинг ХК (**MSE:MLG**) нь олон нийтэд нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчид болон хөрөнгийн зах зээлийн нийт оролцогчдод мэдээллээ илүү нээлттэй, ил тод, хүртээмжтэй хүргэж, оролцогч талуудтай хэрхэн байнгын, зөв харилцаатай байх тал дээр онцгой анхаарч ажиллаж байна.

Хөрөнгө оруулагчидтай харилцах (Investor Relation) функцээ сайжруулах зорилгоор Монложистикс Холдинг ХК нь мэргэжлийн судалгаа, зөвлөх үйлчилгээний компани болох СММ Коммуникаци ба Адвайзорийс ХХК-тай 2024 оны 3-р сараас эхлэн хамтран ажиллаж, дараах олон ажлуудыг 2024 онд хийж гүйцэтгэлээ.

Тухайлбал:

- Хөрөнгө оруулагчидтай харилцах стратеги боловсруулах;
- Компанийн суурь судалгаа хийх;
- Хөрөнгө оруулагчдын хандлагын судалгаа хийх;
- IR сувгууд, ажлын календарьчилсан төлөвлөгөө боловсруулах;
- Хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээлэл бэлдэх;
- One Page Teaser;
- Earnings Call зохион байгуулах;
- Telegram сонсгол хийх;

Хөрөнгө оруулагчидтай харилцах стратегийг компанийн өсөлтийн стратегитэй уялдуулан, богино, дунд болон урт хугацааны стратегийн зорилгыг дараах байдлаар тодорхойлов.

Богино хугацааны IR зорилго: Хөрөнгийн зах зээлийн оролцогчдод салбар, бизнес модель, компани ойлгуулах, хоёр талт мэдээллийн урсгалыг сайжруулах.

Дунд хугацааны IR зорилго: Олон улсын сайн жишигт нийцсэн IR-г хэрэгжүүлдэг Монгол Улсын үлгэр жишээ компани болох.

Урт хугацааны IR зорилго: Монгол Улсад төдийгүй бүс нутгийн хэмжээнд хөрөнгө оруулагчдад ээлтэй, ил тод, ёс зүйтэй, үлгэр жишээ компани болох.

Энэ зорилгын хүрээнд Монложистикс Холдинг ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал З.Шинэ-Од Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 8 үнэт цаасны компани, тэдгээрийн төлөөлөл, мэргэжлийн оролцогч талуудтай уулзаж компанийн санхүүгийн үзүүлэлт, ирээдүйн чиг хандлагын талаар дэлгэрэнгүй танилцуулж, санал солилцож ажиллалаа. Үүний үр дүнд үнэт цаасны компаниудтай хамтран ажиллах эхлэл тавигдаж байна.





5

Дотоод хяналтын ТОГТОЛЦОО

Үйл ажиллагааны тайлан 2024

ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Монложистикс Групп нь “Гурван шугамын загвар”-ын зарчмаар дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн, үйл ажиллагааны бүхий л шатанд хяналтыг чиг үүргийнхээ дагуу дараах байдлаар хэрэгжүүлэн ажилладаг.

Дотоод хяналтын тогтолцооны гурван шугамын загвар



Монложистикс Групп нь дараах үйл ажиллагаануудад тасралтгүй хяналт тавьж, бизнесийн үйл ажиллагааг эрсдэлгүй, тогтвортой явуулахад анхааран ажилладаг. Үүнд:

- Компанийн засаглал, мөрдөгдөж буй дүрэм журам, эрх зүйн баримт бичгүүдийн нийцлийг үнэлэх, зөвлөмж өгөх;

- Бизнес төлөвлөгөө, түүний хэрэгжилт, гадаад, дотоод орчны нөлөөллийн эрсдэлийг тодорхойлох, түүнд хариу арга хэмжээ авах үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, зөвлөмж өгөх;
- Дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- Удирдлагын тогтолцооны стандартуудын хэрэгжилтэд дотоод аудит хийх, зөвлөмж өгөх, аудитын дагуу хийсэн сайжруулалтын үр нөлөөтэй байдлыг үнэлэх;

Эрсдэлийн удирдлага

Группийн хэмжээнд нийт 6 охин компанид Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэнтэй холбогдуулан “Эрсдэлийн удирдлагын журам”-ыг 2025 оны 11-р сард шинэчлэн баталлаа. Монложистикс Группийн хэмжээнд бизнесийн, тактикийн болон үйл ажиллагааны (ХАБЭА) түвшний эрсдэлүүдийг үнэлэн тогтоож, эрсдэлийн нөлөөллийг бууруулах, боломжийг ашиглах төлөвлөгөөг охин компани бүрийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан боловсруулж, хэрэгжүүлдэг. Энэхүү шинэчилсэн “Эрсдэлийн удирдлагын журам”-аар Группийн Эрсдэлийн баг, компани бүрийн эрсдэл хариуцсан ажилтнууд, тэдгээрийн үйл ажиллагааны процесс зураглал, хэрэгжүүлэх алхмуудыг илүү оновчтой зохион байгуулсны зэрэгцээ эрсдэл, боломжийн түвшинг тогтоох шатлал, аргачлалыг тодорхойлж, хяналт тайлагналын арга замуудыг нарийвчлан журамласан.

Өнгөрөгч 2024 онд Монложистикс Группийн хэмжээнд гадаад болон дотоод орчны нийт 68 эрсдэлийг PESTLE, Porter’s 5, McKinsey 7S зэрэг олон улсын стандарт аргачлалын дагуу тодорхойлсны дотор өрш орнуудын дайны нөхцөл байдлаас үүдсэн санхүүгийн хориг, тээврийн маршрутын өөрчлөлт, ханшийн эрсдэл, улс хоорондын төлбөр тооцооны эрсдэлүүд хамгийн өндөр түвшинд байлаа. Эдгээр гадаад хүчин зүйлсээс шалтгаалсан эрсдэлүүдээс гадна дотоод орчинд эдийн засгийн хямрал, түүхий эдийн ханшийн уналт 2025 онд ч мөн үргэлжилж, ачаа эргэлтийн хугацаа удаашрах, тээврийн өртөг нэмэгдэх, хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурах, инфляц, гадаад валютын ханш өсөх зэрэг Группийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөхүйц нөхцөл байдлыг үүсгэх магадлал өндөр байна.

Нийцлийн удирдлага

Монложистикс Группийн бизнесийн үйл ажиллагаа болон компанийн дотоод эрх зүйн хэм хэмжээ нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актууд, олон улсын гэрээ, конвенци, олон улсын стандарт болон үндэсний стандарт, эрх бүхий байгууллага албан тушаалтнаас гаргасан шийдвэр, дүрэм журам, бусад шаардлагууд (цаашид нийтэд нь “Хууль, эрх зүйн хэм хэмжээ” гэх)-д нийцэж байгаа эсэхийг үнэлэх, компани, түүний ажилтнууд нь хууль, эрх зүйн болон компанийн дотоод эрх зүйн хэм хэмжээг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, дагаж мөрдүүлэх, хууль эрх зүйн хэм хэмжээний нэмэлт өөрчлөлтөд компанийн дотоод хэм хэмжээний актуудыг тухай бүр нийцүүлэх, боловсронгуй болгож сайжруулах, компанийн үйл ажиллагаанд тулгарч болох хууль эрх зүйн эрсдэлийг илрүүлж, эрсдэлийг бууруулахтай холбогдох өргөн хүрээтэй цогц үйл ажиллагааг хэрэгжүүлснээр Монложистикс Группийн хэмжээнд хууль, эрх зүйн хэм хэмжээг зөрчсөний үр дүнд үүсч болох хууль эрх зүй, санхүүгийн болон компанийн нэр хүндийн эрсдэлээс сэргийлэх, компанид нийцлийн соёлыг бүрдүүлж, төлөвшүүлэх өргөн цар хүрээтэй цогц үйл ажиллагааг нийцлийн удирдлагаар зохицуулдаг.

2024 онд шинэчлэн батлагдсан “Нийцлийн журам”-ын дагуу зохицуулалтад суурилсан нийцлийн үнэлгээг дараах 6 бүлэгт хийсэн. Үүнд:

- Тээврийн буюу үндсэн үйл ажиллагаатай холбогдох багц хуулиудын нийцлийн үнэлгээ;
- Хөдөлмөрийн харилцааны багц хуулиудын нийцлийн үнэлгээ;
- Мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын багц хуулиудын нийцлийн үнэлгээ;
- ХАБЭАБО-ны холбогдох багц хуулиудын нийцлийн үнэлгээ;
- Санхүү, татвар, нийгмийн хамгааллын багц хуулиудын нийцлийн үнэлгээ;
- Компани, үнэт цаас гаргагчийн багц хуулиудын нийцлийн үнэлгээ;

Дээрх 6 бүлэгт хамаарах эрх зүй, хэм хэмжээний актуудыг судлаж, шалгах асуултуудыг боловсруулан, Нийцлийн журмын дагуу үнэлж, үл нийцэл бүрийн эрсдэл болон магадлалыг тооцон, залруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн.

Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл

Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөгдөхөөс сэргийлэх үндсэн үүргийнхээ хүрээнд ТУЗ-өөс “Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ыг 2024 онд шинээр баталсан. Монложистикс Холдинг ХК-ийн хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын болон компанийн эрх ашгийг тэргүүнд тавих, ашиг сонирхлын зөрчил бий болохоос урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг тодорхойлох, хэлцэл байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах уг журмын дагуу компанийн хэмжээнд хийгдэж буй аливаа хэлцлийг хуулийн дагуу хийгдэж байгаад хяналт тавьж, сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг тухай бүрт олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлсэн.

ТУЗ-ийн 2024 оны 2-р сарын 07-ны өдрийн ээлжит хурлаар Монложистикс Холдинг ХК-ийг охин компаниудад менежментийн зөвлөх үйлчилгээний үзүүлэх гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай №24/ТУЗ/09 тоот сонирхлын зөрчил бүхий хэлцэл хийх тогтоолыг баталсан.

№	Монложистикс Холдинг ХК-тай Менежментийн үйлчилгээний гэрээ байгуулах охин компанийн нэр	Гэрээний үнийн дүн
1	Монложистикс Ворлдвайд ХХК	172,800,000 төгрөг
2	Монложистикс Транзит ХХК	43,000,000 төгрөг
3	Монложистикс Карго ХХК	3,000,000 төгрөг
4	Монложистикс Тракинг ХХК	3,000,000 төгрөг
5	Каус Аустралис ХХК	4,000,000 төгрөг

Дотоод аудит

Монложистикс Группийн хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Employee day” арга хэмжээний хүрээнд дотоод аудитыг сурталчлах сарын аяныг эхлүүлж, группийн хэмжээнд зургаан төрлийн ажлыг амжилттай зохион байгууллаа. ТУЗ-ийн Дотоод аудитор Б.Тамжиддорж 2024 оны 4-р сард Монголын Дотоод Аудиторуудын Институтийн албан ёсны эрхтэй “Үндсэн шалтгааны шинжилгээ хийж дотоод аудитын үр нөлөөг дээшлүүлэх нь” сургалтыг орчуулан бэлтгэж, хамтран зохион байгууллаа.

Дотоод аудиторын 2024 оны 4 сар хүртэлх хугацаанд Монложистикс Ворлдвайд ХХК, Монложистикс Тракинг ХХК-д хийсэн дотоод аудитын ажлын тайлан танилцуулах, мөн Дотоод аудиторын 2024 оны 2-р улиралд Монложистикс Транзит ХХК, Монложистикс Карго ХХК, Каус Аустралис ХХК-д хийсэн дотоод аудитын ажлын тайлан танилцуулсанаас гадна жилийн эцсээр Дотоод аудитын 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг АЭУХ-нд танилцуулах уулзалтуудыг зохион байгууллаа.

Шүгэл үлээх тогтолцоо

Монложистикс Групп, түүний оролцогч талуудын эрх ашиг, сайн сайхны төлөө хууль бус, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг шүгэл үлээгчийн оролцоотойгоор олж илрүүлэх, таслан зогсоох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шүгэл үлээгчийг хамгаалах замаар компанийн сайн засаглал, зөв соёлыг төгөлдөржүүлэхийн тулд шүгэл үлээх тогтолцоог илүү боловсронгуй болгох, шүгэл үлээх орчныг бүрдүүлэхэд анхаарч, “Шүгэл үлээх бодлого”-ыг 2024 онд шинэчлэн батлуулж, шүгэл үлээх цахим системийг ашиглалтанд орууллаа. <https://investor.mlholding.mn/shugel-uleekh/> цахим хуудсаар зочлон дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.

Хэрхэн шүгэл үлээх вэ?

- > Компанийн вебсайтын шүгэл үлээх цэсээр дамжуулан илгээх
- > Шүгэл үлээх маягт бөглөж, нотлох баримтын хамт имэйлээр илгээх
- > Биечлэн уулзаж, шүгэл үлээх маягт бөглж өгөх

Группийн хэмжээнд хийгдсэн дотоод хяналтын тогтолцооны үнэлгээ

Компанийн нийт ажилтнуудаас CoCo загвараар судалгаа авч, үр дүнг нэгтгэн ТУЗ-ийн дэргэдэх АЭУХороонд танилцуулж, зөвлөмж авсан. Судалгааны үр дүнг 2023 онтой харьцуулахад засаглалын үнэлгээ, дотоод хяналтын тогтолцооны үнэлгээ, эрсдэлийн удирдлагын үнэлгээ тус тус өссөн үзүүлэлттэй гарсан нь бид дотоод хяналтын тогтолцоогоороо дамжуулан засаглал, эрсдэл, хяналтын функцүүдийг богино хугацаанд үр нөлөөтэй зохион байгуулж, хэрэгжүүлэн ажиллаж чадаж байгаагийн нэг илэрхийлэл болж байна.



Хөндлөнгийн баталгаажуулалт

Монложистикс Холдинг ХК, түүний охин компаниудын 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх Нэгтгэсэн санхүүгийн байдал болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн болохыг хараат бус, хөндлөнгийн аудит болох Грант Тронтон Аудит ХХК баталгаажуулсан.



6

Санхүүгийн тайлан

Үйл ажиллагааны тайлан 2024

НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Орлогын тайлангийн үзүүлэлт (сая ₮)	2022	2023	2024
Борлуулалтын орлого	136,095	210,361	296,858
Борлуулалтын өртөг	(119,548)	(192,253)	(272,477)
Нийт ашиг	16,547	18,108	24,381
Борлуулалт, Удирдлагын зардал	(6,244)	(8,482)	(11,191)
Бусад орлого	1,455	(35)	775
Бусад зардал	(344)	(289)	(1,271)
Үйл ажиллагааны цэвэр ашиг	11,415	9,302	12,695
Санхүүгийн орлого (зардал)	(385)	283	(749)
Татварын өмнөх цэвэр ашиг (ЕВТ)	11,029	9,585	11,946
ОАТ-н зардал	(1,642)	(1,222)	(1,600)
Цэвэр ашиг	9,387	8,363	10,346
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	8,065	5,925	7,339
Хяналтын эрхгүй хувь оролцоо	1,322	2,438	3,008
Бүх дэлгэрэнгүй орлого			
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	(212)
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	(138)	(62)	(106)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	9,249	8,301	10,028
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	7,927	5,863	7,020
Хяналтын эрхгүй хувь оролцоо	1,322	2,438	3,008
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	9,249	8,301	10,028
Нэгж хувьцаанд ноогдох ашиг суурь ашиг (алдагдал)	20.37	14.97	18.54

НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт (сая ₮)	2022	2023	2024
Мөнгөн хөрөнгө	14,198	22,122	8,709
Дансны авлага	19,504	22,535	40,036
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	2,461	1,811
Бараа материал	103	135	8,025
Урьдчилж төлсөн төлбөр	5,662	6,050	21,257
Бусад эргэлтийн хөрөнгө	258	1,274	2,242
Эргэлтийн хөрөнгө	39,725	54,577	82,080
Үндсэн хөрөнгө	1,449	1,526	5,466
Ашиглах эрх бүхий хөрөнгө	-	952	559
Бусад эргэлтийн бус хөрөнгө	923	553	787
Гүүдвил	-	-	3,463
Эргэлтийн бус хөрөнгө	2,372	3,031	10,275
Нийт хөрөнгө	42,097	57,609	92,355
Дансны өглөг	14,591	12,409	22,059
Урьдчилж орсон орлого	1,558	837	8,004
Богино хугацаат зээл	-	17	6,733
Бусад өглөг	597	465	457
Богино хугацаат өр төлбөр	16,746	13,728	37,253
Урт хугацаат өр төлбөр	212	442	6,452
Нийт өр төлбөр	16,959	14,169	43,705
Эздийн өмч	23,138	39,285	42,325
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	2,001	4,154	6,325
Нийт Эздийн өмч	25,138	43,439	48,650
Нийт өр төлбөр ба Эздийн өмч	42,097	57,609	92,355

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлт

2022 2023 2024

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн	141,813	208,264	286,243
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	139,280	205,059	259,445
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-	15
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	181	83	167
Буцаан авсан албан татвар	1	-	926
Татаас, санхүүжилтийн орлого	-	-	-
Бусад мөнгөн орлого	2,351	3,122	25,690
Мөнгөн зарлагын дүн	132,430	203,784	299,841
Ажиллагчдад төлсөн	3,810	5,414	7,616
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,208	1,358	1,921
Бараа материал худалдан авахад төлсөн	14	53	38,682
Ашиглалтын зардалд төлсөн	9	134	95
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	111,634	186,877	171,759
Хүүний төлбөрт төлсөн	241	10	371
Татварын байгууллагад төлсөн	3,753	4,263	12,310
Даатгалын төлбөрт төлсөн	243	338	342
Бусад мөнгөн зарлага	11,518	5,339	66,745
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,382)	4,480	13,598

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн	221	1,416	9,956
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	3	1	215
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	416	3,109
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-	500
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	155	604	4,708
Хүлээн авсан хүүний орлого	64	394	1,233
Хүлээн авсан ногдол ашиг	-	-	-

Мөнгөн зарлагын дүн	1,215	3,806	24,418
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	134	280	7,862
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	117	31	130
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	3,301	7,292
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	46
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	964	195	9,087
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(994)	(2,390)	(14,4962)

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн	6,918	11,383	44,385
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,775	6,431	59,527
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,308	10,968	-
Төрөл бүрийн хандив	-	-	0
Бусад санхүүгийн мөнгөн орлого	835	22	-
Мөнгөн зарлагын дүн	7,648	11,383	44,385
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,621	9,832	39,743
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	337	584	785
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	3,001	-	-
Төлсөн ногдол ашиг	853	190	3,823
Бусад санхүүгийн мөнгөн зарлага	853	778	34
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(730)	6,037	15,142
Валютын ханшийн зөрүү	724	(203)	(495)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(8,383)	7,924	13,413
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,816	14,198	22,122
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,198	22,122	8,709

НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн үзүүлэлт (сая ₮)	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт дүн
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	106	(3,001)	2,234	(139)	23,937	23,138	2,001	25,138
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	5,925	5,925	2,438	8,363
Өмчид гарсан өөрчлөлт	12	-	-	-	-	12	-	12
Халаасны хувьцаа	-	(3,001)	-	-	(671)	2,330	-	2,330
Нэмж төлөгдсөн капитал	-	-	7,954	-	-	7,954	-	7,954
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	(73)	-	(73)	(85)	(158)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	(200)	(200)
2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	119	-	10,188	(212)	29,191	39,285	4,154	43,439
Нягтлан бодох бүртгэлийн залруулга	-	-	-	11	52	63	22	85
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	7,339	7,339	3,008	10,346
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	329	329	342-	670
Халаасны хувьцаа	-	(1,427)	-	-	-	(1,427)	-	(1,427)
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-	-	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	(106)	(212)	(319)	-	(319)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(2,945)	(2,945)	(1,200)	(4,145)
2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	119	(1,427)	10,188	(307)	33,753	42,325	6,325	48,650

ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

ТАЙЛАГНАЛЫН НИЙЦЭЛ

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг Олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)–өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”), Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн, Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт 10 “Нэгтгэсэн санхүүгийн Тайлан” стандартын аргачлалыг ашиглан бэлтгэсэн.

БҮРТГЭЛИЙН СУУРЬ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг аккруэль сууриар бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, хөрөнгө оруулалт болон тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийг түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ТОЛИЛУУЛГЫН ВАЛЮТ

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг үйл ажиллагааны валют буюу Монгол төгрөгөөр толилуулсан.

ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг бүртгэхдээ ажил гүйлгээ гарсан өдрийн Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг тайлант хугацааны эцэст тайлагналын өдрөөр зарласан албан ханшийг ашиглан дахин хөрвүүлдэг. Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсийг тухайн бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар, түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаадвалютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гадаад валютаар санхүүгийн тайлан бэлтгэдэг охин компанийн санхүүгийн тайланг нэгтгэхдээ тухайн санхүүгийн тайланг Монгол төгрөгт хөрвүүлдэг. Тайлант үеийн орлого болон зардлыг ажил гүйлгээ гарсан өдрийн спот ханшаар, бүх хөрөнгө ба өр төлбөрийн балансын дансдыг санхүү байдлын тайлагналын өдрөөр зарласан албан ханшаар хөрвүүлэн тайлагнадаг. Хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз, гарзыг эзэмшигчийн өмчийн хэсэгт гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц хэсэгт ангилан толилуулдаг.

МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГТАХ ХӨРӨНГӨ

Мөнгөтэй адилгтах хөрөнгөнд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай 3 хүртэлх сарын хугацаатай хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилгтах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Групп нь тухайн санхүүгийн хэрэглүүрт хамаарах гэрээний оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Дансны болон бусад авлага, гэрээний хөрөнгийг хялбаршуулсан аргаар үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тусгадаг. Санхүүгийн өр төлбөрт зээл, дансны болон бусад өглөг, үүсмэл санхүүгийн хэрэгслүүд орох ба ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг анх олж авснаасаа хойш түүнийг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бүртгэж харуулдаг. Үндсэн үйл ажиллагааг явуулахтай холбоотой ашиглагдах хангамжийн зүйлсийг хангамжийн материал гэх дансанд бараа материалын бүртгэлтэй адилаар ангилж бүртгэдэг.

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Ирээдүйд тухайн хөрөнгөөс эдийн засгийн өгөөж олж авах магадлалтай бөгөөд хөрөнгийн өртгийг үнэн зөв найдвартай хэмжих боломжтой тохиолдолд үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг ба үндсэн хөрөнгийн дараа үеийн хүлээн зөвшөөрөлттэй холбоотойгоор тайлагналдаа хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр тайлагнадаг.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн бүх үндсэн хөрөнгүүдийг элэгдүүлэхдээ шулуун шугамын аргыг ашиглан хөрөнгийн элэгдүүлэх дүнг тооцсон хугацааны туршид системтэйгээр хуваарилан орлогын тайланг бүртгэдэг.

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Биет бус хөрөнгийн анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хөрөнгийг олж эзэмшсэн аргаас хамааран өртгөөр нь эсхүл бодит үнэ цэнээр бүртгэдэг. Биет бус хөрөнгийг шулуун шугамын аргаар хоргодуулдаг ба хорогдлын зардал, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр нь үнэлэн тайлагнадаг.

БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БҮЙ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ / БЭЭБЭБХ/

БЭЭБЭБХ-ийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш түүнийг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бүртгэж харуулдаг. БЭЭБЭБХ -ийн үнэ цэнийн өсөлт, бууралтыг тайлант хугацааны ашиг/алдагдлаар хүлээн зөвшөөрнө. БЭЭБЭБХ анх хүлээн зөвшөөрөхөд СТОУС 5 стандартын дагуу тухайн хөрөнгийн дансны үнэ болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлэн бүртгэдэг ба тус бүлгийн хөрөнгийг элэгдүүлэхгүй.

ТҮРЭЭС

Гэрээ нь санхүүгийн түрээс эсэх, эсвэл санхүүгийн түрээсийг агуулсан эсэхийг компани нь уг гэрээ үүссэн өдрөөр үнэлдэг. Санхүүгийн түрээс эхлэх өдрөөр санхүү байдлын тайландаа ашиглах эрхийн хөрөнгө болон түрээс өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Ашиглах эрхийн хөрөнгийг шулуун шугамын аргаар гэрээний нөхцөл болон тухайн хөрөнгийн ашиглах жилийн аль багаар элэгдүүлдэг. Түрээс эхлэх өдөр өр төлбөрийг тооцохдоо ирээдүйн түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг түрээсийн нуугдмал хүүний түвшинг (тодорхойлох боломжгүй бол зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшинг) ашиглан дискаунтчлан тооцдог.

АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААНЫ ТЭТГЭМЖ

Ажилчдад олгох богино хугацааны тэтгэмж ажилчид холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилийн тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор олгох тэтгэмж бөгөөд цалин урамшуулал, ээлжийн амралтын олговор, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэл болон бусад нийгмийн төлбөрүүд багтана.

ХУВЬЦААТ КАПИТАЛ, НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ

Энгийн хувьцаа нь хувьцааны нэрлэсэн үнээр илэрхийлэгдэнэ. Нэмж төлөгдсөн капиталд хувьцаат капитал гаргаснаас хүлээж авсан аливаа урамшуулал орох ба хувьцаа гаргахтай холбоотой шууд зардлыг холбогдох татвар суутгасан цэвэр дүнгээр нэмж төлөгдсөн капиталаас хасдаг.

ОРЛОГО, ЗАРДАЛ

Үндсэн үйл ажиллагаанд тулгуурлан орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгахдаа СТОУС 15-ын дагуу худалдан авагчтай байгуулсан гэрээний үүргийн гүйцэтгэлээр буюу хугацааны туршид хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгадаг. Үйлчлүүлэгчтэй гэрээгээр тохирсон дүнг борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрөхөд гүйцэтгэлийн хувийн жинг баримтлах бол гэрээнд тусгаагүй нэмэлтээр үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой борлуулалтын орлогыг үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Борлуулалтын өртгийг борлуулалтын орлоготой уялдуулж санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулдаг. Борлуулалт маркетинг, ерөнхий удирдлагын зардал, бусад зардлыг нийт дүнгээр нь толилуулдаг.

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар буюу тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тооцоолсон татвар болон санхүү, татварын суурийн зөрүүнээс тооцоолсон хойшлогдсон татвараас бүрдэнэ.

ТАЙЛБАР ТОЛЬ

Монложистикс Групп эсвэл Групп	Монложистикс Холдинг ХК болон түүний охин компаниудыг хамтад нь
Толгой компани	Монложистикс Холдинг ХК
Охин компани	Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтад заасан хуулийн этгээдүүд
Зэргэлдээ компани	Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.15 дахь заалтад заасан хуулийн этгээдүүд
Компанийн нэгдэл	Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.14 дэх заалтад заасан хуулийн этгээдүүд
MSE	Монголын Хөрөнгийн Бирж
MLG	Монложистикс Группийн Монголын хөрөнгийн бирж дээрх симбол
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
IPO	Нийтэд анх удаа хувьцаа санал болгох
ESG	Байгаль орчин, Нийгэм, Засаглал 3 үгийн товчлол

ROE	Өөрийн хөрөнгийн өгөөж
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
VWAP	Volume weighed average price / дундаж үнэ/
НББОУСЗ	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
БЗЭБЭБХ	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө
SWIFT	Олон улсын төлбөр тооцооны систем
Subsidy	Татаас
ISO	Олон улсын стандартчиллын байгууллага
PR	Олон нийтийн харилцаа
ХОМК	Хөрөнгө оруулалт менежментийн компани
СЭЗИС	Санхүү эдийн засгийн их сургууль
ESOP	Employee Stock Ownership Plan
KESO	Гол ажитнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөрлбөр
ХАБЭАБО	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй байгаль орчин
CoCo	Дотоод хяналтын үнэлгээний загвар

FLSmith	Өргөн, өндөр, хэт овортой ачаа
Core system	Үндсэн систем
Dashboard	Интерактив мэдээллийн дүрслэл, дүн шинжилгээ хийх хэрэгсэл
ERP	Нэгдсэн нөөцийн төлөвлөлтийн систем
RPA	Процессын автоматжуулалт
DMS	Баримт бичгийн менежемент
LMS	Тээврийн бүртгэлийн систем
DWH	Өгөгдлийн нэгдсэн сан
AI	Хиймэл оюун ухаан
IoT	Интернэтэд холбогдсон, өгөгдөл цуглуулж, солилцох чадвартай ухаалаг төхөөрөмжүүдийн сүлжээ
WTO	Дэлхийн худалдааны байгууллага
Investor relation	Хөрөнгө оруулагчтай харилцах
M&A	Нэгдэх, худалдан авах замаар компанийг өөртөө нэгтгэх
B2B	Бизнесээс бизнесүүдтэй хийх борлуулалт
B2C	Бизнесээс хэрэглэгчдэд хийх борлуулалт
OPT	Тээврийн менежмент үзүүлэлт

ТАЙЛБАР ТОЛЬ

Тохируулах бичилт	Группийн аж ахуй нэгж хооронд хийгдсэн гүйлгээ, үлдэгдлийг устгах бичилт	Нийт ашгийн хувь	=	$\frac{\text{Нийт ашиг} * 100}{\text{Борлуулалтын орлого}}$
Restated	Дахин тайлагнасан санхүүгийн тайлан	Цэвэр ашгийн хувь	=	$\frac{\text{Цэвэр ашиг} * 100}{\text{Борлуулалтын орлого}}$
		Өөрийн хөрөнгийн өгөөж	=	$\frac{\text{Тайлант үеийн ашиг}}{\text{Эздийн өмч}}$
		Өөрийн хөрөнгийн харьцаа	=	$\frac{\text{Монложистикс группийн эздийн өмч}}{\text{Нийт хөрөнгө}}$
		Үйл ажиллагааны эргэц	=	$\left(\frac{360}{\text{Худалдан авалт}} \times \frac{\text{Дундаж бараа}}{\text{материал}} \right) + \left(\frac{360}{\text{Авлага}} \times \frac{\text{Дундаж}}{\text{авлага}} \right)$
		Эргэлтийн харьцаа	=	$\frac{\text{Эргэлтийн хөрөнгө}}{\text{Богино хугацаант өр төлбөр}}$
		Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	=	$\frac{\text{Эргэлтийн хөрөнгө} - \text{Бараа материал}}{\text{Богино хугацаант өр төлбөр}}$
		Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг	=	$\frac{\text{Монложистикс ногдох тайлант үеийн ашиг}}{\text{Хувьцаа тоо ширхэг}}$



ХАЯГ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Нью горизонтс оффис, 11 давхар, 1101 тоот

ХОЛБОО БАРИХ

+976 7701-5454

info@mlholding.mn

www.mlholding.mn